

# АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ (USAID)

“Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил  
тод байдлыг нэмэгдүүлэх (BEST)” төсөл

## “ХӨДӨӨ АЖ АХУЙН СУУРЬ СУДАЛГАА”

### ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

# 2023

Төсөл хэрэгжиж байгаа байршлуудад бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, зорилтот салбарын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нар энэхүү суурь судалгаанд хамрагдсан.



[contact@dsmongolia.org](mailto:contact@dsmongolia.org)



[www.dsmongolia.org](http://www.dsmongolia.org)



УБ хот, СБД, 1-р хороо,  
Downtown, 5-501 тоот өрөө

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-ийн санхүүжилттэй,  
“Хөгжлийн Шийдэл” төрийн бус байгууллага (ТББ)-аас хэрэгжүүлж буй  
“Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх (BEST)” төсөл

## Талархал

Энэхүү суурь судалгааны ажлын мэдээлэл цуглуулах ажлын зохион байгуулалтад мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн төслийн нэгж, түүний орон нутгийн салбарын хамт олон; Үндэсний статистикийн хорооны зарим шинжээчид; мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар; дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв болон Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг, бизнесийн сургууль зэрэг байгууллага, хамт олон, хувь хүмүүст гүн талархсанаа илэрхийлье.

# “ХӨДӨӨ АЖ АХУЙН СУУРЬ СУДАЛГАА”-НЫ ТАЙЛАН

## 2023 ОН

## ЗӨВЛӨХ БАГ



“Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” НҮТББ

Багийн бүрэлдэхүүн:

Т.Эрдэнэчулуун (Багийн ахлагч, Ph.D.)  
Г.Энх-Амгалан (Багийн гишүүн, M.Sc.)  
Ц.Батнаран (Багийн гишүүн, M.Sc.)  
О.Амартүвшин (Багийн гишүүн, M.Sc.)  
Г.Билгүүн (Багийн гишүүн, M.Sc.)  
Ч.Батжаргал (Багийн гишүүн, M.Sc.)  
Ц.Цэрэндаваа (Багийн гишүүн, M.Sc.)



Монгол Улс, Улаанбаатар хот, 17024  
Хан-Уул Дүүрэг, Зайсан, 11-р хороо,  
ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль, 215 тоот;



Цахим хуудас: [www.inrae.mn](http://www.inrae.mn)

И-мэйл: [info@inrae.mn](mailto:info@inrae.mn)



Утас: +976 9909 2644, +976 9907 2958, +976 9811 2347

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	i
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	ii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	ii
ХАВСРАЛТАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iii
НЭГ. ОРШИЛ .....	1
1.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал .....	1
1.2 Зорилтот салбарын эдийн засагт эзлэх байр суурь.....	1
1.3 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр.....	2
ХОЁР. АРГА ЗҮЙН ТОЙМ .....	3
2.1 Судлагдсан байдлын тойм .....	3
2.2 Суурь судалгааны ажлын зорилго, зорилт болон хамрах цар хүрээ, үе шат .....	3
2.3 Өгөгдөл цуглуулах ашигласан арга, аргачлал болон түүврийн хэмжээ.....	5
2.3.1 Өгөгдөл цуглуулахад ашигласан арга.....	5
2.3.2 Өгөгдөл цуглуулах ажлын хүрээнд хийсэн зохион байгуулалтын ажлын тойм.....	6
2.3.3 Түүврийн хэмжээ, төлөөлөх чадвар .....	6
2.4 Өгөгдөл баталгаажуулалт, боловсруулалт болон шинжилгээнд ашигласан арга.....	7
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	9
3.1 Тоон судалгааны үр дүн.....	9
3.1.1 Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл.....	9
3.1.2 Бизнесийн суурь мэдээлэл.....	12
3.1.3 Өрсөлдөх чадвар болон нөөцийн менежмент.....	17
3.1.4 Чанарын баталгаажуулалт .....	25
3.1.5 Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа ба өөрчлөлтийн бэлэн байдал .....	25
3.1.6 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдал.....	40
3.2 Уулзалт, ярилцлагын авсан чанарын судалгааны үр дүн.....	42
3.1.1 Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөж болон тулгамдаж буй асуудал.....	42
3.2.2 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор арилжааны банкнаас олгож буй зээлийн бүтээгдэхүүн.....	47
3.3 Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудлууд.....	48
3.3.1 Газар тариалангийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал.....	48
3.3.2 Мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал.....	51
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ .....	56
4.1 Дүгнэлт .....	56
4.2 Санал .....	64
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	66
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ .....	68

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БОХААЭЗХ	Байгаль орчин, Хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн
ГТ	Газар тариалан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДБЭ	Жижиг, дунд бизнес эрхлэгчид
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан
ЖДҮҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
МАА	Мал аж ахуй
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага
УУ	Уул уурхай
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭАА	Хувиараа эрхлэх аж ахуй
INRAE	Institute of Natural resources and Agricultural economics
ISO	International organization for Standardization
RCA	Revealed Comparative Advantage
USAID	U.S. Agency for International Development

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ДНБ-д зорилтот салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь	2
Хүснэгт 2. Түүврийн үнэлгээ_1	7
Хүснэгт 3. Түүврийн үнэлгээ_2	7
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл_1	9
Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл_2	10
Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл_3	11
Хүснэгт 7. Бизнесийн суурь мэдээлэл_1	12
Хүснэгт 8. Бизнесийн суурь мэдээлэл_2_Мал аж ахуйн салбар	14
Хүснэгт 9. Бизнесийн суурь мэдээлэл_2_Газар тариалангийн салбар	15
Хүснэгт 10. Бизнесийн суурь мэдээлэл_2_Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбар	15
Хүснэгт 11. Бизнесийн суурь мэдээлэл_2_Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын салбар	16
Хүснэгт 12. Бизнес төлөвлөлт	21
Хүснэгт 13. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн нөөцийн менежмент, зорилтот салбар болон бүртгэлтэй эсэхээр	23
Хүснэгт 14. Чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлт	25
Хүснэгт 15. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа_1	25
Хүснэгт 16. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа_2	28
Хүснэгт 17. Бизнесийн хэрэгцээ, шаардлага_зорилтот	32
Хүснэгт 18. Санхүүгийн хэрэгцээ, шаардлага_1	32
Хүснэгт 19. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага_Мал аж ахуйн салбар	34
Хүснэгт 20. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага_Газар тариалангийн салбар	35
Хүснэгт 21. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага_Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбар	37
Хүснэгт 22. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага_Тээвэр, агуулахын салбар	38

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын эдийн засгийн чиг хандлага	1
Зураг 2. Монгол Улсын ЖДҮ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр	2
Зураг 3. “Хөдөө аж ахуйн суурь судалгаа”-ны үндсэн үе шат, цар хүрээ	4
Зураг 4. Өгөгдлийг хянах, засварлах, кодлох үйл явц	8
Зураг 5. Суурь судалгаанд хамрагдсан оролцогчдын хамрах цар хүрээ, хэв шинж	9
Зураг 6. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт	17
Зураг 7. Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт	18
Зураг 8. Газар тариалангийн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт	18
Зураг 9. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт	19
Зураг 10. Тээвэр, агуулахын салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт	19
Зураг 11. Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал	19
Зураг 12. Газар тариалангийн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал	20
Зураг 13. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал	20
Зураг 14. Тээвэр, агуулахын салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал	21
Зураг 15. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нөөцийн менежмент	22
Зураг 16. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа_3	29
Зураг 17. Бизнесийн хэрэгцээ, шаардлага	30
Зураг 18. Санхүүгийн хэрэгцээ, шаардлага_2	33
Зураг 19. Төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал	49
Зураг 20. Үр тариа (улаанбуудай)-ны үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал	50
Зураг 21. Мах, махан бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал	52

Зураг 22. Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал.....	54
--	----

### **ХАВСРАЛТАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

<i>Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буй зорилтот салбарын үйл ажиллагааны чиглэл.....</i>	<i>68</i>
<i>Хавсралт 2. Суурь судалгааны орон нутагт ажиллах ажлын ерөнхий удирдамж.....</i>	<i>69</i>
<i>Хавсралт 3. Тоон өгөгдөл цуглуулах судалгааны асуулга_Хавсралт файл №1.....</i>	<i>70</i>
<i>Хавсралт 4. Чанарын өгөгдөл, мэдээлэл цуглуулах судалгааны ажлын удирдамж_Хавсралт файл №2..</i>	<i>70</i>
<i>Хавсралт 5. Судалгаанд хамрагдсан нэгжийн эх олонлог_Үйл ажиллагаа явуулж буй нийт жижиг, дунд бизнес эрхлэгч.....</i>	<i>70</i>
<i>Хавсралт 6. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид (зорилтот салбар, үйл ажиллагааны тоо болон бүртгэлтэй эсэхээр).....</i>	<i>72</i>


## НЭГ. ОРШИЛ

### 1.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

Монгол Улсын эдийн засгийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр илэрхийлсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д үндэслэн тооцоход:

- 2022 оны эхний 9 сарын байдлаар 3.7 хувиар өсөж (2021 оны эхний 9 сартай харьцуулахад), цар тахлын үеийн эдийн засгийн уналт эргэн сэргэх хандлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, цар тахлын өмнөх үе буюу 2018 онд эдийн засаг 7.7 хувийн өсөлттэй байсан бол дэлхий нийтийг хамарсан цар тахлын үеүдэд эдийн засаг уналтад орсон (2020 онд -4.6 хувь болтол буурсан). Харин сүүлийн 2 жилд эдийн засгийн өсөлт 3.7 хувь болтол өсөж, сэргэх хандлага ажиглагдаж байна.
- Мөн манай улсын эдийн засаг 3.7 хувиар өсөхөд Хөдөө аж ахуй (ХАА), Аж үйлдвэр, Барилга болон Үйлчилгээний салбар эерэг нөлөө, Уул уурхай, олборлолтын салбар сөрөг нөлөө үзүүлсэн байна. Дэлгэрэнгүйг [Зураг №1](#)-с харна уу.

Зураг 1. Монгол Улсын эдийн засгийн чиг хандлага



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны статистик мэдээлэл, [www.1212.mn](http://www.1212.mn)

Тайлбар: \* 2022 оны эхний 9 сарын гүйцэтгэлийг 2021 оны эхний 9 сарын гүйцэтгэлтэй харьцуулав.

\*\* ДНБ-ий 2022 оны эхний 9 сарын гүйцэтгэлийн дүн.

### 1.2 Зорилтот салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Суурь судалгааны зорилтот салбарууд болох хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл (хүнсний үйлдвэрлэл) болон тээвэр, агуулахын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр, байр суурийг ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр)-д тухайн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь гэсэн үзүүлэлтээр харуулав. Сүүлийн 5-н жилийн дундаж үзүүлэлтээс харахад манай улсын ДНБ-ий 14.1 хувийг хөдөө аж ахуйн салбараас, 8 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбараас, 5.1 хувийг тээвэр, агуулахын салбараас тус тус бүрдүүлж байна. Мөн хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 0.9 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 1.3 пунктээр тус тус өссөн бол тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 8.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Дэлгэрэнгүйг [Хүснэгт №1](#)-с харна уу.

Хүснэгт 1. ДНБ-д зорилтот салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь

Зорилтот салбар	2018	2019	2020	2021	Дундаж
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	13.6	13.6	15.1	14.0	14.1
Боловсруулах үйлдвэрлэл	7.8	7.7	8.4	8.1	8.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.6	5.5	4.7	4.3	5.1
<b>Нийт дүн</b>	<b>27.0</b>	<b>26.8</b>	<b>28.2</b>	<b>26.4</b>	<b>27.2</b>

Эх сурвалж: ҮСХ-ны статистик мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)

### 1.3 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр


“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуульд зааснаар жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг:

- 10 хүртэл ажилтантай, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой “Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”;
- 10-50 хүртэл ажилтантай, жилийн 300.0 сая - 1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой “Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч”;
- 50-200 хүртэл ажилтантай, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой “Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж ангилсан байдаг.

Дээрх ангиллын дагуу жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ (ЖДҮҮ) эрхлэгчдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг ҮСХ-ны хоёрдогч мэдээлэл ашиглан боловсруулж харуулав.

ЖДҮ эрхлэгчдийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 оны байдлаар 2073.8 тэрбум төгрөг болж, 2020 онтой харьцуулахад 14.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Мөн ЖДҮҮ эрхлэгчдийн нэмэгдэл өртгийн хэмжээ ДНБ-ий 5.5 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.1 пунктээр буурсан байна. Мэдээллийн дэлгэрэнгүйг [Зураг №2](#)-д харуулав.

Зураг 2. Монгол Улсын ЖДҮ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр



Эх сурвалж: ҮСХ-ны статистик мэдээлэл, [www.1212.mn](http://www.1212.mn)



## ХОЁР. АРГА ЗҮЙН ТОЙМ

### 2.1 Судлагдсан байдлын тойм

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-ийн санхүүжилттэй уг төслийн суурь судалгааны ажлын арга зүй боловсруулах зорилгоор өмнө нь энэ чиглэлээр хийсэн нийт 25 судалгааны ажлын тайлан, эмхэтгэл зэрэг баримт бичиг судалсан. Энэ хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээ, хөдөө аж ахуйн бизнес, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр олон улсын болон үндэсний түвшний байгууллагаас Монгол Улсын жишээн дээр хийсэн судалгааны ажлын тайлан, нийтлэл, өгүүлэл, бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн үнэлгээ, нөлөөллийн үнэлгээ зэрэг материалыг судалж авч үзэв. Судалгааны ажлын арга, аргачлалыг авч үзэхэд 80 хувь нь түүвэрлэлтийн аргаар судалгаанд хамрагдах оролцогчдыг сонгон ганцаарчилсан асуулга болон фокус группийн аргад тулгуурлан зайнаас эсвэл уламжлалт аргаар цаасан судалгааны бэлдсэн асуулгуудыг тусгай программ дээр электрон хэрэгсэл, телефон утас, google form гэх мэт судалгааны аргуудыг ашиглан анхдагч мэдээллийг цуглуулж, нэмэлт тоон мэдээллүүдийг ҮСХ, олон улсын байгууллагуудын албан ёсны хоёрдогч мэдээллийн эх сурвалжийг ашиглан, тоон болон чанарын мэдээллийг цуглуулж, бүлэглэх, хүснэгтээр нэгтгэх, график дүрслэл хийх замаар боловсруулалт хийж, дүгнэлт хийсэн байна. Бусад ажлууд нь тоон шинжилгээний арга, аргачлал ашиглан тооцоолол хийсэн байна.

Олон улсын байгууллагуудаас хийсэн судалгааны ажлуудаас харахад үндэсний болон бүс нутгийн түвшинд ХАА-н дэд салбарууд болох мал аж ахуй, газар тариалан зэрэг салбарын бизнесийн оролцогч талуудыг хамруулан авч үзэж, судалгаагаа хийсэн ба ХАА-н чиглэлийн жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДҮ)-тэй холбоотой судалгааны ажлуудад ихэвчлэн тоон шинжилгээний арга зүйг ашигласан байна.

Харин үндэсний түвшний байгууллагуудын хийсэн судалгааны ажлуудаас үзэхэд ХАА-н салбарын ЖДБ эрхлэгчдийн талаар үндэсний болон бүс нутгийн түвшинд, мөн МАА, ГТ, худалдаа үйлчилгээ, тээвэр, логистикийн салбарууд дах нийлүүлэлтийн болон үнэ цэний сүлжээний оролцогч талуудыг хамруулан судалгаа хийсэн ба Монгол Улсын ХАА-н салбарын өнөөгийн байдал, өрсөлдөх чадварын талаар тоймлож, экспортын давуу тал бүхий ХАА-н бүтээгдэхүүнийг харьцангуй давуу талын (revealed comparative advantage) индекс ашиглан тодорхойлж, уг бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаар судалсан байна. Түүнчлэн статистик шинжилгээний харьцуулалт, корреляцийн шинжилгээ, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон салбарын хөдөлмөрийн бүтээмж болон үндсэн хүчин зүйлийн бүтээмж, хөрөнгө оруулалт гэх мэт хүчин зүйлүүдийн ХАА-н салбарын орлогод хэрхэн нөлөө үзүүлж байгааг хүчин зүйлийн шинжилгээний арга ашиглан тооцоолсон байна.

### 2.2 Суурь судалгааны ажлын зорилго, зорилт болон хамрах цар хүрээ, үе шат

**Зорилго:** Хөдөө аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрлэл болон тээвэр, агуулахын салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал (бизнесийн туршлага, технологи, гол орц, орлого, зарлага, хүнсний аюулгүй байдал, хувийн хэвшлийн оролцоо, жендер гэх мэт өргөн хүрээнд)-д үнэлэлт өгч, тулгамдаж буй асуудал, сорилт, боломжийг тодорхойлох; анхдагч болон хоёрдогч

өгөгдөл, мэдээлэл ашиглан үнийн цэний сүлжээний ерөнхий зураглал гаргах; цаашлаад төсөл хэрэгжүүлэгч нэгжид жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн зөвлөмж боловсруулахад чиглэсэн.


**Хамрах цар хүрээ, объект:** Дээр дурдсан салбаруудын түвшинд 6 дэд салбар, 28 чиглэлийн үйл ажиллагаа (анги) эрхэлж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдээс энэхүү суурь судалгааг авсан. Мөн энэхүү судалгаанд хөтөлбөр хэрэгжиж буй:

- Баруун бүсийн Ховд болон Завхан аймгууд;
- Хангайн бүсийн Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл болон Орхон аймгууд;
- Төвийн бүсийн Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь болон Сэлэнгэ аймгууд;
- Зүүн бүсийн Дорнод болон Хэнтий аймгууд;
- Нийслэл Улаанбаатар хотны 9 дүүрэг болон түүний орчмын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчид хамрагдав.

Түүнчлэн чанарын өгөгдөл, мэдээлэл цуглуулах зорилгоор орон нутаг (12 аймаг)-ийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Хүнс, хөдөө аж ахуйн газар-ХХААГ), арилжааны банкны төлөөлөл (ХААН банк, ХАС банк, Төрийн банк), мэргэжлийн салбарын холбоод/төрийн бус байгууллага (ТББ)-ын төлөөллийг хамруулсан ганцаарчилсан уулзалт; Баруун бүсээс Ховд аймаг, Төвийн бүсээс Сэлэнгэ аймаг, Зүүн бүсээс Дорнод аймгийг хамруулсан, 5 хүртэл жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцсон бүлгийн уулзалтыг зохион байгуулав. Ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг тухайн маршрут хариуцсан багийн ахлагч нар хийж гүйцэтгэсэн. Суурь судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зорилтот салбаруудын үйл ажиллагааны чиглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [Хавсралт №1](#)-с харна уу.

**Судалгааны үндсэн үе шат:** “Хөдөө аж ахуйн суурь судалгаа”-г [Зураг №3](#)-д харуулсан үндсэн үе шатуудтай хийж гүйцэтгэсэн.

Зураг 3. “Хөдөө аж ахуйн суурь судалгаа”-ны үндсэн үе шат, цар хүрээ



## 2.3 Өгөгдөл цуглуулах ашигласан арга, аргачлал болон түүврийн хэмжээ

### 2.3.1 Өгөгдөл цуглуулахад ашигласан арга

Төсөл хэрэгжиж буй 12 аймгийн төвийн сумд болон Улаанбаатар хотын 9 дүүрэг, түүний орчмын бүсийн нийт 800 нэгжийг судалгаанд хамруулж, тоон болон чанарын шинж чанартай анхдагч мэдээллийг цуглуулж авсан. Суурь судалгааны ажлын ерөнхий удирдамжийг [Хавсралт №2](#)-с харна уу. Тоон болон чанарын шинж чанартай анхдагч өгөгдөл цуглуулахад дараах үндсэн хоёр аргыг ашигласан. Үүнд:

- Тоон өгөгдөл цуглуулах зорилготой *Асуулга (Questionnaire)*-ын арга;
- Чанарын өгөгдөл цуглуулах зорилготой *Ярилцлага (Interviews)*-ын арга:
  - *Ганцаарчилсан (one-on-one interviews)* болон;
  - *Бүлгийн (focus group interviews)* ярилцлагын аргууд ашигласан.

Мөн ярилцлага хийхэд:

- *Бүтэцлэгдсэн (structured)* болон;
- *Хагас бүтэцлэгдсэн (semi-structured)* ярилцлагын хэлбэрүүдийг ашиглав.

Тоон шинж чанартай анхдагч мэдээллийг цуглуулахад:

- Захиалагч талаас санал болгосон зорилтод салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа,
- Бизнес регистрийн санд бүртгэлтэй болон бүртгэлгүй,
- Хариуцлагын хэлбэрийн хувьд хоршоо, нөхөрлөл, хувьцаат компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) гэсэн хэлбэрээр тус тус үйл ажиллагаа эрхэлж ЖДҮ-ээс,
- Захиалагч талаар батлуулсан асуулга ([Хавсралт №3](#))-ын дагуу өгөгдөл, мэдээлэл цуглуулж авсан (questionnaire).

Чанарын шинж чанартай анхдагч мэдээллийг цуглуулахад:

- Төсөл хэрэгжиж буй аймгуудын ХХААГ-ын төлөөлөл, Арилжааны банкны төлөөлөл болон мэргэжлийн холбоо / ТББ-ын төлөөллийг хамруулан,
- Бүтэцлэгдсэн ярилцлагын хэлбэрийг ашиглан уулзалт хийж, чанарын шинж чанартай анхдагч мэдээллийг цуглуулав.
- Мөн захиалагч талын саналыг үндэслэн зөвлөх багийн гишүүд Баруун бүсээс Ховд аймгийг, Төвийн бүсээс Сэлэнгэ аймгийг, Зүүн бүсээс Дорнод аймгийг тус тус сонгон авч:
  - Хагас бүтэцлэгдсэн ярилцлагын хэлбэрийг ашиглан ЖДҮ-ийн 4-5 төлөөлөлтэй бүлгийн уулзалт хийж, чанарын шинж чанартай нэмэлт мэдээллийг цуглуулж авсан ([Хавсралт №4](#)).

Харин суурь судалгаанд шаардлагатай нэмэлт хоёрдогч мэдээллийг цуглуулахад:

- ҮСХ-ны статистикийн эмхэтгэл, томоохон тооллогын хүрээнд хийгдсэн сэдэвчилсэн судалгаанууд;
- Бусад яам, агентлаг болон судалгааны чиглэлийн дотоодын байгууллагуудын тайлан, эмхэтгэл болон;
- ОУБ, төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгааны тайлангуудыг гол эх сурвалж болгож, цахим болон хэвлэмэл материалуудыг ашигласан.

### 2.3.2 Өгөгдөл цуглуулах ажлын хүрээнд хийсэн зохион байгуулалтын ажлын тойм

Нэг. Суурь судалгааны өгөгдөл, мэдээлэл цуглуулах ажлын баг нь үндсэн 4 маршрутаар ажилласан бөгөөд Маршрут №1 нь баруун чиглэлд Өвөрхангай, Баянхонгор, Ховд, Завхан аймгуудад, Маршрут №2 нь хойд чиглэлд Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад, Маршрут №3 нь зүүн чиглэлд Хэнтий, Дорнод аймгуудад, урд чиглэлд Өмнөговь аймагт, Маршрут №4 нь урд чиглэлд Дорноговь аймагт тус тус ажиллаж, орон нутгаас тоон болон чанарын шинж чанартай анхдагч мэдээллийг цуглуулсан. Мөн эдгээр бүх багууд (маршрут) Улаанбаатар хотод ажилласан.

Хоёр. Мөн Улаанбаатар, түүний орчмын бүс болон орон нутгийн ЖДҮ-ийг судалгаанд хамруулж, өгөгдөл цуглуулах зорилгоор захиалагч тал, түүний орон нутгийн нэгжүүд болон гүйцэтгэгч талаас шаардлагатай албан бичиг, зохион байгуулалтын ажлуудыг хийсэн.

Гурав. Мэдээлэл, өгөгдөл цуглуулах ажлын хүрээнд тулгарч байсан гол бэрхшээлтэй асуудлууд, түүнийг шийдвэрлэсэн байдал:

- Цаг агаарын өөрчлөлт: Энэхүү бэрхшээлээс шалтгаалан орон нутагт мэдээлэл, өгөгдөл цуглуулах ажлыг төлөвлөж байсан хугацаанаас 7 хоногоор хойшлуулж эхэлсэн ба энэхүү 7 хоногийн хугацаанд Улаанбаатар хотод ажиллахаар өөрчлөлт оруулсан.
- Судалгаанд хамрагдсан нэгж, түүнтэй холбоо тогтоох: Субъектив хүчин зүйлээс хамаарсан гол бэрхшээлтэй асуудал байсан. Анх бүртгэлтэй ЖДҮ-ийг судалгаанд хамруулах зорилгоор зорилтот салбаруудаар нийт 3656 ЖДҮ-ийн холбоо утас, хаягийн мэдээллийг урьдчилан бэлтгэсэн боловч, холбоо барих боломжгүй, судалгаа өгөхөөс татгалзсан, үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд явуулаагүй гэх мэт олон шалтгаанаас хамааран судалгаанд хамрагдах хувь хангалтгүй болсон. Энэхүү асуудал Улаанбаатар хотод мэдээлэл, өгөгдөл цуглуулах ажлын үед тулгарсан. Иймд захиалагч талтай санал солилцож, Улаанбаатар хот, түүний орчмын бүсээс судалгаанд хамрагдах нэгжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн ХХААГ-тай холбоо тогтоож, хил залгаа Төв аймгийн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ-ийн мэдээллийг авч, судалгаанд хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

### 2.3.3 Түүврийн хэмжээ, төлөөлөх чадвар

Түүврийн хэмжээ: Анх захиалагч талаар батлуулсан арга зүйгээр нийт 3652 жижиг, дунд бизнес эрхлэгч болон бусад төлөөллөөс 1000 нэгжийг суурь судалгаанд хамруулахаар төлөвлөсөн. Гэсэн хэдий ч 2.2 дэд бүлэгт дурдсан саад бэрхшээлээс шалтгаалан төсөл хэрэгжиж буй 12 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, түүний орчмын бүс (Төв аймгийн хил залгаа 11 сумд)-ийн нийт 3842 жижиг, дунд бизнес эрхлэгчид болон бусад төлөөллөөс тоон судалгаанд 761 нэгж, чанарын судалгаанд 39 нэгж, нийт 800 нэгжийг хамруулсан. Судалгаанд хамрагдсан түүврийг хэмжээг төсөл хэрэгжиж буй байршлаар авч үзэхэд:

- Нийт судалгаанд хамрагдсан нэгжийн 26.5 хувийг Улаанбаатар хотын 9 дүүрэг, түүний орчмын бүсийн Төв аймгийн 11 сумдаас;

- 22.5 хувийг Төвийн бүсийн төсөл хэрэгжиж буй 4 аймгаас;
- 22.1 хувийг Хангайн бүсийн төсөл хэрэгжиж буй 4 аймгаас;
- 18.6 хувийг Баруун бүсийн төсөл хэрэгжиж буй 2 аймгаас;
- 10.3 хувийг Зүүн бүсийн төсөл хэрэгжиж буй 2 аймгаас авсан түүврийн хэмжээ тус тус бүрдүүлсэн. Дэлгэрэнгүйг судалгааны үр дүн хэсгийн ерөнхий мэдээлэл болон [Хавсралт №5-с](#) харна уу.

**Түүврийн төлөөлөх чадвар:** Манай улсын практикт нийтлэг 5-10 хувийн түүврээр суурь судалгаа хийж, судалгааны үр дүнг тодорхойлж харуулсан байдаг.

Энэхүү суурь судалгаа нь 21 орчим хувийн түүврийг судалгаанд хамруулж, судалгааны үр дүнг гаргаж авсан. Хэрэв 95 хувийн итгэх түвшин (confidence level)-тэй, 5 хувийн алдаа (margin of error)-тай түүвэр явуулна гэж үзвэл нийт 3842 нэгжээс багадаа 350 нэгжийг судалгаанд хамруулахад болж байна.

*Хүснэгт 2. Түүврийн үнэлгээ\_1*

Үзүүлэлт	Үр дүн
Итгэх түвшин (Confidence level)	95.0 %
Алдаа (Margin of error)	5.0%
Эх олонлог (Population size)	3842
<b>Түүврийн хэмжээ (Sample size)</b>	<b>350</b>

*Эх сурвалж: Судлаачдын тооцсон үр дүн*

Харин бидний суурь судалгааны хувьд нийт 3842 нэгжээс 800 нэгжийг судалгаанд хамруулсан нь түүврийн алдааны хэмжээг 3.08 хувь хүртэл багасгаж, түүврийн төлөөлөх чадварыг нэмэгдүүлж байна.

*Хүснэгт 3. Түүврийн үнэлгээ\_2*

Үзүүлэлт	Үр дүн
Итгэх түвшин (Confidence level)	95.0 %
Түүврийн хэмжээ (Sample size)	800
Эх олонлог (Population size)	3842
<b>Алдаа (Margin of Error)</b>	<b>3.08%</b>

*Эх сурвалж: Судлаачдын тооцсон үр дүн*

## **2.4 Өгөгдөл баталгаажуулалт, боловсруулалт болон шинжилгээнд ашигласан арга**

**Өгөгдлийг хянах, засварлах болон кодлох:** Энэхүү үйл ажиллагаа нь асуулга боловсруулах, турших, засаж сайжруулах үе шатуудтай нягт улдаатай хийсэн ба дараах зурагт харуулсан үндсэн алхмуудтай хийсэн.


**Өгөгдөл баталгаажуулах, засварлах (Data validation & editing):** Тухайн өдрийн судалгаа авах үйл ажиллагаа дуусах тухай бүрд маршрутын багийн ахлагч өөрийн хариуцсан судлаач нарын авсан судалгааг хянаж, алдаа гарсан тохиолдолд судалгаанд оролцогч нартай биечлэн болон утсаар холбогдож, гарсан алдааг цахим дата бааз (KoboToolbox)-д засаж, тухайн асуулгыг баталгаажуулж (approve) байсан.

Мөн тоон болон чанарын судалгаа дууссаны дараа зөвлөх багийн гишүүд өгөгдлийг цахим дата баазаас татан авч, боловсруулалтад бэлтгэх үед логик дараалалтай

асуултыг хянах, цаашлаад тоон өгөгдлийн хураангуй статистикийг тооцож, хэрэв механик алдаа гарсан бол засвар хийж, өгөгдлийг дахин баталгаажуулсан.

Өгөгдлийг цэгцлэх, кодлох (Data coding): Судалгааны өгөгдлийг бусад төрлийн буюу MS Office, SPSS зэрэг программд оруулж, боловсруулалт хийхэд бэлтгэж, судалгааны асуултуудыг кодолсон.

Зураг 4. Өгөгдлийг хянах, засварлах, кодлох үйл явц



Эх сурвалж: Судлаачдын үр дүн

Өгөгдлийг боловсруулах, шинжлэх: Дүрслэлийн статистик (Descriptive statistics) ашиглан захиалагч талын саналыг харгалзан судалгааны үзүүлэлтүүдийг байршил, үйл ажиллагааны чиглэл, хариуцлагын хэлбэр, бүртгэлтэй эсэх гэсэн үндсэн бүлгүүдээр боловсруулалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгсөн. Мөн статистикийн хүснэгт, график, дундаж, харьцуулалт хийх замаар судалгааны үр дүнг гаргаж, түүнд үнэлэлт, дүгнэлт өгсөн. Цаашлаад эдийн засгийн болон статистик, эконометрикийн шинжилгээний арга зүйд үндэслэн суурь судалгааны чанарын үр дүнг гарган авсан ба статистикийн программ хангамжуудыг тохиромжтой хувилбаруудаар ашигласан.

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Суурь судалгаанд жижиг, дунд бизнес эрхлэгчид болон төрийн, төрийн бус байгууллага/мэргэжлийн холбоод, арилжааны банкны төлөөллөөс бүрдсэн нийт 800 оролцогч хамрагдсан ба жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тоон судалгаанд (асуулга судалгаа), төрийн байгууллага, төрийн бус байгууллага/мэргэжлийн холбоо, арилжааны банк болон жижиг, дунд бизнесийн 3-5 төлөөллийг чанарын судалгаанд (ганцаарчилсан болон бүлгийн уулзалт) хамруулсан ([Зураг №5](#)). Тоон судалгааны үр дүнг 3.1 дэд бүлэгт, чанарын судалгааны үр дүнг 3.2 дэд бүлэгт тус тус харуулав. Мөн тоон болон чанарын судалгаанд хамрагдсан оролцогчдын бүтэц, хэв шинжийг дараах зургаас харна уу.

Зураг 5. Суурь судалгаанд хамрагдсан оролцогчдын хамрах цар хүрээ, хэв шинж



Эх сурвалж: Судалгааны үр дүн

### 3.1 Тоон судалгааны үр дүн

#### 3.1.1 Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл

**Зорилтот салбар болон үйл ажиллагааны чиглэлээр:** Судалгаанд хамрагдсан нийт 760 жижиг, дунд бизнес эрхлэгчид зорилтот үндсэн дөрвөн салбарт нийт 1013 үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь 7 бизнес эрхлэгч тутмын хоёр нь дунджаар 2 өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг харуулж байна. Төсөл хэрэгжиж буй байршлаар дэлгэрэнгүй үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл 1

**Нэг. Судалгаанд хамрагдсан нийт 760 бизнес эрхлэгчдийн хувьд:**

7 бизнес эрхлэгч тутмын 2 бизнес эрхлэгч нь: Дунджаар 2 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг.

**Хоёр. Судалгаанд хамрагдсан Баруун бүсийн 2 аймгийн нийт 142 бизнес эрхлэгчдийн хувьд:**

7 бизнес эрхлэгч тутмын 4 бизнес эрхлэгч нь: Дунджаар 2 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг.

**Гурав. Судалгаанд хамрагдсан Зүүн бүсийн 2 аймгийн нийт 75 бизнес эрхлэгчдийн хувьд:**

7 бизнес эрхлэгч тутмын 3 бизнес эрхлэгч нь: Дунджаар 2 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Дөрөв. Судалгаанд хамрагдсан Хангайн бүсийн 4 аймгийн нийт 165 бизнес эрхлэгчид, Төвийн бүсийн 4 аймгийн нийт 167 бизнес эрхлэгчид болон Улаанбаатар хот, түүний орчмын бүсийн нийт 211 бизнес эрхлэгчдийн хувьд:

7 бизнес эрхлэгч тутмын 2 бизнес эрхлэгч нь: Дунджаар 2 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх ерөнхий үр дүнг зорилтот салбаруудаар авч үзвэл давхардсан тоогоор мал аж ахуйн салбарт хамаарах нийт 10 төрлийн үйл ажиллагааны чиглэлд нийт 206 бизнес эрхлэгч 236 үйл ажиллагаа эрхэлж байна. Харин газар тариалангийн салбарт 292 бизнес эрхлэгч тухайн салбарт хамаарах нийт 8 төрлийн үйл ажиллагааны чиглэлд 393 үйл ажиллагаа, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 286 бизнес эрхлэгч тухайн салбарт хамаарах нийт 7 төрлийн үйл ажиллагааны чиглэлд 297 үйл ажиллагаа эрхэлдэг бол тээвэр, агуулахын болон дундын зуучлал, борлуулалтын салбарт 87 бизнес эрхлэгч тухайн салбарт хамаарах нийт 5 төрлийн үйл ажиллагааны чиглэлд 87 үйл ажиллагаа эрхэлж байна. Дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл\_2

Нэг. Мал аж ахуйн салбарын үйл ажиллагааны чиглэл		Үйл ажиллагааны тоо
1.1 Малын тэжээл тариалалт		41
1.2 Малын үржил, селекци		5
1.3 Мал эмнэлгийн үйлчилгээ		52
1.4 Сүүний аж ахуй		46
1.5 Махны чиглэлийн аж ахуй		40
1.6 Шувууны аж ахуй		17
1.7 Гахайн аж ахуй		12
1.8 Загасны аж ахуй		1
1.9 Зөгийн аж ахуй		21
1.10 Малын тэжээл үйлдвэрлэл		1
Эрхэлж буй үйл ажиллагааны нийт тоо		236
Давхардсан тоогоор бизнес эрхлэгчдийн тоо		206
Хоёр. Газар тариалангийн салбарын үйл ажиллагааны чиглэл		Үйл ажиллагааны тоо
2.1 ХАА-н машин механизм, тоног төхөөрөмж		3
2.2 Ургамал, хөрс хамгаалал		3
2.3 Бордоо/химийн бодис/, усалгаа		1
2.4 Үр сорт		53
2.5 Хүлэмжийн аж ахуй		68
2.6 Төмс, хүнсний ногоо тариалан		179
2.7 Жимс, жимсгэнэ тариалан		37
2.8 Үр тариа тариалалт		49
Эрхэлж буй үйл ажиллагааны нийт тоо		393
Давхардсан тоогоор бизнес эрхлэгчдийн тоо		292
Гурав. Хүнс боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны чиглэл		Үйл ажиллагааны тоо
3.1 Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл		80
3.2 Сүү, цагаан идээн бүтээгдэхүүн үйлдвэрлэл		76
3.3 Хүнсний ногоон бүтээгдэхүүн		5
3.4 Жимс, жимсгэнэ бүтээгдэхүүн		13
3.5 Гурил, үр тариан бүтээгдэхүүн үйлдвэрлэл		25
3.6 Талх нарийн боов		87
3.7 Органик, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл		11
Эрхэлж буй үйл ажиллагааны нийт тоо		297
Давхардсан тоогоор бизнес эрхлэгчдийн тоо		286



Дөрөв. Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын салбарын үйл ажиллагааны чиглэл	Үй ажиллагааны тоо
4.1 Махны зоорь	10
4.2 Хүнсний ногооны зоорь	20
4.3 ХАА-н бүтээгдэхүүний савлагаа	4
4.4 ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний дундын борлуулалт/зуучлагч	18
4.5 ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт	35
4.6 Өвс, малын тэжээлийн агуулах	0
Эрхэлж буй үйл ажиллагааны нийт тоо	87
Давхардсан тоогоор бизнес эрхлэгчдийн тоо	87

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн нийт судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 87.2 хувь нь зөвхөн нэг л салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бол бусад бизнес эрхлэгчид 2-4 салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн нийт бизнес эрхлэгчдийн 74.7 хувь зөвхөн нэг төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад бизнес эрхлэгчдийн хувьд тухайн зорилтот салбаруудад хамаарах 2-6 төрлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэхүү үр дүнгийн дэлгэрэнгүйг [Хавсралт №6-с](#) харна уу.

**Бүртгэлтэй эсэх болон хариуцлагын хэлбэрээр:** Мөн судалгаанд хамрагдсан нийт 760 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 80.8 хувийг бизнес регистрийн санд бүртгэлтэй бизнес эрхлэгчид, 19.2 хувийг бүртгэлгүй бизнес эрхлэгчид (ХЭАА) бүрдүүлж байгаа ба нийт бүртгэлтэй жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 29.5 хувийг хоршоо, нөхөрлөл, 70.5 хувийг хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл\_3

Төсөл хэрэгжиж буй байршил	Бизнес регистрийн санд					Нийт дүн
	Бүртгэлтэй				Бүртгэлгүй ХЭАА	
	Нөхөрлөл	Хоршоо	ХК	ХХК		
<b>Баруун бүс</b>						
Завхан / Улиастай	1	13	-	32	12	58
Ховд / Жаргалант	13	24	-	28	19	84
<b>Хангайн бүс</b>						
Баянхонгор аймаг / Баянхонгор	1	6	-	22	11	40
Орхон / Баян-Өндөр	-	10	1	24	8	43
Өвөрхангай / Арвайхээр	-	13	-	18	15	46
Хөвсгөл / Мөрөн	1	4	1	26	4	36
<b>Төвийн бүс</b>						
Дархан-Уул / Дархан	1	5	-	39	20	65
Дорноговь / Сайншианд	-	1	-	12	6	19
Өмнөговь / Даланзадгад	1	13	-	35	16	65
Сэлэнгэ / Сүхбаатар	1	3	-	10	4	18
<b>Зүүн бүс</b>						
Дорнод / Хэрлэн	2	3	1	39	11	56
Хэнтий / Хэрлэн	2	1	-	11	5	19
Улаанбаатар хот, орчмын бүс	2	60	-	134	15	211
<b>Нийт дүн</b>	<b>25</b>	<b>156</b>	<b>3</b>	<b>430</b>	<b>146</b>	<b>760</b>

Эх сурвалж: Судалгааны үр дүн

### 3.1.2 Бизнесийн суурь мэдээлэл

А. Санхүүгийн зарим суурь үзүүлэлтүүд: Судалгаанд хамрагдсан нийт 760 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд нэг бизнес эрхлэгч 2021 оны байдлаар жилд дунджаар 103.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг эргэлтэд оруулж, 253.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглаж, 228.9 сая төгрөгийн орлого олж байна. Энэхүү үр дүнг зорилтот салбарууд болон бүртгэлтэй эсэхээр тооцож, үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Бизнесийн суурь мэдээлэл\_1

Зорилтот салбар		Бүртгэлтэй эсэх	Үзүүлэлт	Тоон утга	
Нэг. нийт салбаруудын хувьд:	Зорилтот нийт салбаруудын хувьд:	Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо	614	
			Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт		
			Эргэлтийн хөрөнгө, сая.төг	124.2	
			Үндсэн хөрөнгө, сая.төг	297.4	
	Борлуулалтын орлого, сая.төг			271.4	
	Бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо	Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт		
			Эргэлтийн хөрөнгө, сая.төг	16.2	
			Үндсэн хөрөнгө, сая.төг	73.4	
			Борлуулалтын орлого, сая.төг	53.8	
	Хоёр. ахуйн хувьд:	Мал аж салбарын хувьд:	Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	177
Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт					
Эргэлтийн хөрөнгө, сая.төг				97.3	
Үндсэн хөрөнгө, сая.төг				232.8	
Борлуулалтын орлого, сая.төг			206.6		
Бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд:		Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт		
			Эргэлтийн хөрөнгө, сая.төг	11.3	
			Үндсэн хөрөнгө, сая.төг	67.3	
			Борлуулалтын орлого, сая.төг	47.5	
Гурав. тариалангийн салбарын хувьд:		Газар тариалангийн салбарын хувьд:	Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	225
	Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт				
	Эргэлтийн хөрөнгө, сая.төг			121.8	
	Үндсэн хөрөнгө, сая.төг			298.4	
	Борлуулалтын орлого, сая.төг			280.4	
	Бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт		
			Эргэлтийн хөрөнгө, сая.төг	13.0	
			Үндсэн хөрөнгө, сая.төг	78.6	
			Борлуулалтын орлого, сая.төг	30.5	
	Дөрөв. боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд:	Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд:	Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд:	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	229
Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт					
Эргэлтийн хөрөнгө, сая.төг				134.4	
Үндсэн хөрөнгө, сая.төг				330.3	
Борлуулалтын орлого, сая.төг			321.2		
Бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд:		Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт		
			Эргэлтийн хөрөнгө, сая.төг	21.4	
			Үндсэн хөрөнгө, сая.төг	47.5	
			Борлуулалтын орлого, сая.төг	87.7	

Тав.	Тээвэр, агуулах	Бүртгэлтэй бизнес	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	70
			<i>Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт</i>	
дундын	зуучлал,	эрхлэгчдийн	Эргэлтийн хөрөнгө, сая.төг	166.3
борлуулалтын		хувьд:	Үндсэн хөрөнгө, сая.төг	349.2
салбарын хувьд:			Борлуулалтын орлого, сая.төг	242.9
		Бүртгэлгүй бизнес	Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	17
			<i>Нэг бизнес эрхлэгчид ногдох дундаж үзүүлэлт</i>	
		эрхлэгчдийн	Эргэлтийн хөрөнгө, сая.төг	19.5
		хувьд:	Үндсэн хөрөнгө, сая.төг	149.9
			Борлуулалтын орлого, сая.төг	43.4

*Эх сурвалж: Судалгааны үр дүн*

Дээрх хүснэгтээс харахад:

- Зорилтот үндсэн дөрвөн салбарын нийт дүнгээр **бүртгэлтэй** нэг бизнес эрхлэгчийн олж буй орлого **бүртгэлгүй** нэг бизнес эрхлэгчийн олж буй орлогоос 4.5 дахин өндөр байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийг салбаруудаар харьцуулж авч үзэхэд **хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт** үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн олж буй орлогын дундаж хэмжээ хамгийн өндөр байхад **мал аж ахуйн салбарт** үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн энэхүү үзүүлэлт хамгийн бага байна. Энэ нь эргэлтийн хөрөнгийн эргэц, үр өгөөжтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө жилд дунджаар 2.4 удаа эргэлтэд орж байхад бусад салбарын үзүүлэлт үүнээс бага байна.
- Харин бүртгэлгүй бизнес эрхлэгчдийг салбаруудаар харьцуулж авч үзэхэд мөн адил **хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт** үйл ажиллагаа эрхэлдэг бүртгэлгүй бизнес эрхлэгчид хамгийн өндөр орлого олж байхад **газар тариалангийн салбарт** үйл ажиллагаа эрхэлдэг бүртгэлгүй бизнес эрхлэгчид хамгийн бага орлого олж байгаа нь дундаж үзүүлэлтээс харагдаж байна. Мөн эргэцийн тоог харахад мал аж ахуйн салбар дах бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө илүү хурдан эргэлтэд ордог хэдий ч эргэлтийн хөрөнгийн үр өгөөж нь хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийн үр өгөөжтэй харьцуулахад бага байгаа нь тооцооллоос харагдаж байна. Мал аж ахуйн салбар дах бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө жилд дунджаар 4.2 удаа эргэлтэд орж, 47.5 сая төгрөгийн орлого олж байхад хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбар дах бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө жилд дунджаар 4.1 удаа эргэлтэд орж, 87.7 сая төгрөгийн орлого олж байна.

**Б. Ажлын байр, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт:** Судалгаанд хамрагдсан нийт 760 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нийт дүнгээр авч үзэхэд:

- Нийт 7293 байнгын ажлын байранд ажиллах хүч ажиллуулдаг ба нийт байнгын ажлын байрны 52.9 хувьд нь эмэгтэйчүүд ажиллаж байна.
- Мөн нийт 7766 түр ажлын байранд ажиллах хүч түр ажиллуулдаг ба нийт түр ажлын байрны 47.7 хувьд нь эмэгтэйчүүд ажиллаж байна.
- Мөн нийт бизнес эрхлэгчдийн 80.6 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байранд өөрчлөлт ороогүй, 8.8 хувь нь ажиллагсдын тоо өссөн, үлдсэн

10.6 хувь нь ажиллагсдын тоо буурсан гэж хариулсан байна. Эндээс ажлын байрны тоо харьцангуй тогтвортой байна гэж хэлж болохоор байна.

- Бизнес эрхлэгчид ажлын байранд ажиллах хүч ажиллуулахад хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэхэд 37.7 хувь нь байнгын болон түр ажлын байранд гэрээ байгуулдаг, 32.8 хувь нь зөвхөн байнгын ажлын байранд, 1.3 хувь нь түр ажлын байранд ажиллах хүч ажиллуулахад хөдөлмөрийн гэрээ байгуулдаг бол үлдсэн 28.2 хувь нь ажлын байранд гэрээ байгуулдаггүй байна.
- Түүнчлэн ажил олгогч байгууллагаас төлөх ёстой НДШ-ийг 52.5 хувь нь төлдөг гэж хариулсан бол үлдсэн хувь нь төлдөггүй гэж хариулсан байна.

Дээрх ажлын байртай холбоотой суурь судалгааны ерөнхий үр дүнг зорилтот салбарууд болон бүртгэлтэй эсэх гэсэн хэв шинжээр задлан авч үзэж, дараах байдлаар үр дүнг тодорхойлов.

Хүснэгт 8. Бизнесийн суурь мэдээлэл\_2 Мал аж ахуйн салбар

Үзүүлэлт	Бүртгэлтэй	Бүртгэлгүй
1. Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	177	29
2. Нийт ажиллагсдын тоо		
2.1 Нийт байнгын ажиллагсдын тоо	1093	79
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	47.8%	50.6%
2.2 Нийт түр ажиллагсдын тоо	966	152
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	34.4%	52.0%
3. Ажлын байранд гарсан өөрчлөлт		
Ажиллагсдын тоо өссөн	5.1%	3.4%
Ажиллагсдын тоо өөрчлөгдөөгүй	85.9%	82.8%
Ажиллагсдын тоо буурсан	9.0%	13.8%
Нийт	100.0%	100.0%
4. Хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэх		
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаг	35.1%	45.1%
Зөвхөн байнгын ажлын байранд гэрээ байгуулдаг	37.7%	11.8%
Зөвхөн түр ажлын байранд гэрээ байгуулдаг	1.3%	43.1%
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаггүй	25.9	-
Нийт	100.0%	100.0%
5. Ажил олгогчоос төлөх ёстой НДШ төлдөг эсэх		
Тийм	53.1%	13.8%
Үгүй	46.9%	86.2%
Нийт	100.0%	100.0%

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх хүснэгтээс харахад мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн хувьд:

- Нийт ажлын байрны 50 гаруй хувийг байнгын ажлын байр бүрдүүлдэг,
- Байнгын ажлын байран дах хүйсийн харьцаа тэнцвэртэй,
- Ажлын байрны тоо сүүлийн нэг жилийн хугацаанд харьцангуй тогтвортой хадгалагдсан,
- Ихэнх ажил олгогчид хөдөлмөрийн гэрээ байгуулдаг, бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь НДШ төлдөг бол бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн дийлэх нь шимтгэл төлдөггүй байна.

Харин газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн хувьд:

- Нийт ажлын байрны 27 хувийг байнгын ажлын байр бүрдүүлдэг,

- Байнгын ажлын байран дах хүйсийн харьцаа тэнцвэртэй,
- Ажлын байрны тоо сүүлийн нэг жилийн хугацаанд харьцангуй тогтвортой хадгалагдсан,
- Бүртгэлтэй ихэнх бизнес эрхлэгчид хөдөлмөрийн гэрээ байгуулдаг, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн бараг тал хувь нь гэрээ байгуулдаггүй, үүнээс хамааран 80 орчим хувь нь НДШ төлдөг төлдөггүй байна. Үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 9. Бизнесийн суурь мэдээлэл 2 Газар тариалангийн салбар

Үзүүлэлт	Бүртгэлтэй	Бүртгэлгүй
1. Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	225	67
2. Нийт ажиллагсдын тоо		
2.1 Нийт байнгын ажиллагсдын тоо	1663	181
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	47.9%	50.3%
2.2 Нийт түр ажиллагсдын тоо	4242	738
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	47.6%	67.2%
3. Ажлын байранд гарсан өөрчлөлт		
Ажиллагсдын тоо өссөн	9.3%	4.5%
Ажиллагсдын тоо өөрчлөгдөөгүй	81.8%	92.5%
Ажиллагсдын тоо буурсан	8.9%	3.0%
Нийт	100.0%	100.0%
4. Хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэх		
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаг	35.2%	47.2%
Зөвхөн байнгын ажлын байранд гэрээ байгуулдаг	37.6%	4.7%
Зөвхөн түр ажлын байранд гэрээ байгуулдаг	2.7%	0.8%
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаггүй	24.5	47.2%
Нийт	100.0%	100.0%
5. Ажил олгогчоос төлөх ёстой НДШ төлдөг эсэх		
Тийм	55.1%	20.9%
Үгүй	44.9%	79.1%
Нийт	100.0%	100.0%

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дараагийн зорилтот салбар болох хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн хувьд:

Хүснэгт 10. Бизнесийн суурь мэдээлэл 2 Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбар

Үзүүлэлт	Бүртгэлтэй	Бүртгэлгүй
1. Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)	229	57
2. Нийт ажиллагсдын тоо		
2.1 Нийт байнгын ажиллагсдын тоо	2987	180
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	60.8%	76.1%
2.2 Нийт түр ажиллагсдын тоо	1070	123
Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	52.1%	56.1%
3. Ажлын байранд гарсан өөрчлөлт		
Ажиллагсдын тоо өссөн	13.1%	12.3%
Ажиллагсдын тоо өөрчлөгдөөгүй	72.5%	77.2%
Ажиллагсдын тоо буурсан	14.4%	10.5%
Нийт	100.0%	100.0%
4. Хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэх		
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаг	35.3%	47.4%
Зөвхөн байнгын ажлын байранд гэрээ байгуулдаг	44.9%	11.3%
Зөвхөн түр ажлын байранд гэрээ байгуулдаг	0.7%	41.2%
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаггүй	19.1%	-
Нийт	100.0%	100.0%

5. Ажил олгогчоос төлөх ёстой НДШ төлдөг эсэх			
Тийм		70.3%	19.3%
Үгүй		29.7%	80.7%
	<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тухайн салбарын хувьд:

- Нийт ажлын байрны ихэнх хувийг байнгын ажлын байр бүрдүүлдэг,
- Байнгын ажлын байран дах хүйсийн харьцаа эмэгтэйчүүд давамгайлсан,
- Нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байрны тоог тогтвортой хадгалсан болон нэмэгдүүлсэн,
- Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид нийтлэг хөдөлмөрийн гэрээ байгуулдаг хэдий ч бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь НДШ төлдөг төлдөггүй байна.

Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн хувьд:

Хүснэгт 11. Бизнесийн суурь мэдээлэл 2 Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын салбар

	Үзүүлэлт	Бүртгэлтэй	Бүртгэлгүй
<b>1. Нийт бизнес эрхлэгчдийн тоо (давхардсан)</b>			
		70	17
<b>2. Нийт ажиллагсдын тоо</b>			
2.1 Нийт байнгын ажиллагсдын тоо		1069	41
	Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	41.1%	39.0%
2.2 Нийт түр ажиллагсдын тоо		391	84
	Үүнээс: Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	30.9%	32.1%
<b>3. Ажлын байранд гарсан өөрчлөлт</b>			
Ажиллагсдын тоо өссөн		7.1%	5.9%
Ажиллагсдын тоо өөрчлөгдөөгүй		77.1%	94.1%
Ажиллагсдын тоо буурсан		15.7%	-
	<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>
<b>4. Хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэх</b>			
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаг		27.9%	46.9%
Зөвхөн байнгын ажлын байранд гэрээ байгуулдаг		52.3%	3.1%
Зөвхөн түр ажлын байранд гэрээ байгуулдаг		1.2%	3.1%
Бүх ажлын байранд гэрээ байгуулдаггүй		18.6%	47.0%
	<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>
<b>5. Ажил олгогчоос төлөх ёстой НДШ төлдөг эсэх</b>			
Тийм		65.7%	23.5%
Үгүй		34.3%	76.5%
	<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тухайн салбарын хувьд:

- Нийт ажлын байрны ихэнх хувийг байнгын ажлын байр бүрдүүлдэг,
- Байнгын ажлын байран дах хүйсийн харьцаа салбарын онцлогоос хамааран эмэгтэйчүүдийн ажиллах нь бага,
- Бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байрны тоог тогтвортой хадгалсан болон нэмэгдүүлсэн болон бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд ажиллагсдын тоо буураагүй,

- Бүртгэлтэй бизнес эрхлэгчид нийтлэг хөдөлмөрийн гэрээ байгуулдаг, үүнийг дагаад шимтгэл төлөлт өндөр хувьтай байгаа бол бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 50 орчим хувь нь гэрээ байгуулдаггүй, үүнээс шалтгаалан 70 гаруй хувь нь НДШ төлдөг төлдөггүй байна.


Дээрх салбаруудын үр дүнг нэгтгэн дүгнэж, зарим гол үзүүлэлтийг тайлбарлахад:

- Бүртгэлтэй нэг бизнес эрхлэгч дунджаар 10 байнгын ажлын байранд ажиллах хүч авч ажиллуулж байхад бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 3 гарч байна.
- Мөн хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн хувьд илүү их байнгын ажлын байрыг бий болгосон байна.

### 3.1.3 Өрсөлдөх чадвар болон нөөцийн менежмент

**А. Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт ба төлөвлөлт:** Нийт судалгаанд хамрагдсан бүртгэлгүй 146 нэгжийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 82.6 хувьтай байгаа бөгөөд үйлдвэрлэлийн хүчин чадлыг 20 хүртэл хувь ашигладаг 1 нэгж, 20-40 хувь ашигладаг 9 нэгж, 40-60 хувь ашигладаг 19 нэгж, 60-80 хувь ашигладаг 33 нэгж байгаа бол 80-100 хувь ашигладаг бизнес эрхлэгчид хамгийн олон буюу 84 нэгж байна. Харин судалгаанд хамрагдсан бүртгэлтэй 614 нэгжээс үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 74.3 хувь ба өөрийн хүчин чадлыг 20 хүртэл хувь ашигладаг 14 нэгж, 20-40 хувь ашигладаг 53 нэгж, 40-60 хувь ашигладаг 121 нэгж, 60-80 хувь ашигладаг 158 нэгж байгаа бол 80-100 хувь ашигладаг бизнес эрхлэгчид хамгийн олон буюу 268 нэгж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Дараах зургаар бүртгэлгүй болон бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын түвшинг харуулав.

Зураг 6. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Харин судалгаанд хамрагдсан нийт 760 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 2021 оны үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтыг зорилтот салбаруудаар авч үзэж, үр дүнг дараах зургуудаар харуулав.

Нэг. Мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 206 (давхардсан тоогоор) бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 78.7 хувь, ихэнх бизнес эрхлэгчид үйлдвэрлэлийн хүчин чадлыг 80-100 хувь ашиглаж байна. Мөн бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтыг дараах зургаар харуулав.


Зураг 7. Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Хоёр. Газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 292 (давхардсан тоогоор) бизнес эрхлэгчдийн 50 хувь нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг 80-100 хувь ашиглаж байгаа бол 2 хүрэхгүй хувь нь 20 хүртэл хувь хүчин чадал ашиглалттай байна. Мөн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 77.5 хувьтай байгаа бөгөөд бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтыг дараах зургаар харуулав.

Зураг 8. Газар тариалангийн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Гурав. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 286 (давхардсан тоогоор) бизнес эрхлэгчдийн 36 хувь нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг 80-100 хувь ашиглаж байгаа бол 2.1 хувь нь 20 хүртэл хувь хүчин чадал ашиглалттай байна. Мөн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 73 хувьтай байна. Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын үр дүнг дараах зургаар харуулав.




Зураг 9. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дөрөв. Тээвэр, агуулахын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 87 (давхардсан тоогоор) бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 73.9 хувь, 62.1 хувь нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг 60-с дээш хувь ашиглаж байгаа бол 4.6 хувь нь 20 хүртэл хувь хүчин чадал ашиглалттай байна.


Зураг 10. Тээвэр, агуулахын салбарын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалт



Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Үйлдвэрлэлийн төлөвлөлт:** Мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 206 (давхардсан тоогоор) бизнес эрхлэгчдийн 81.1 хувь нь өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөсөн тоог хэмжээг товлосон цагт нь 60-с дээш хувьтай үйлдвэрлэж чаддаг гэж хариулсан бол үлдсэн бизнес эрхлэгчид (19.9 хувь нь) 60-с доош хувьтай төлөвлөлт хийдэг гэж хариулсан. Харин бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр төлөвлөсөн үйлдвэрлэлийн хэмжээг товолсон цаг хугацаанд үйлдвэрлэж чаддаг эсэхэд үнэлгээ өгсөн байдлыг дараах зургаар харуулав. Үнэлгээг 1-10 хүртэл оноогоор үнэлсэн ба 1 оноо бол төлөвлөлт 10 хувьтай, 10 оноо бол 100 хувьтай хийж байгааг харуулна.


Зураг 11. Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Газар тариалангийн салбарын хувьд бизнес эрхлэгчдийн 77.7 хувь нь өөрийн бизнест үйлдвэрлэлийн төлөвлөсөн тоог хэмжээг товлосон цагт нь 60-с дээш хувьтай үйлдвэрлэж чаддаг гэж хариулсан бол үлдсэн бизнес эрхлэгчид (22.3 хувь нь) 60-с доош хувьтай төлөвлөлт хийж чаддаг гэж хариулсан байна. Бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр гарсан үр дүнг дараах зургаас харна уу.


Зураг 12. Газар тариалангийн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд бизнес эрхлэгчдийн 84.9 хувь нь өөрийн бизнест үйлдвэрлэлийн төлөвлөсөн тоог хэмжээг товлосон цагт нь 60-с дээш хувьтай үйлдвэрлэж чаддаг гэж хариулсан бол үлдсэн бизнес эрхлэгчид (15.1 хувь нь) 60-с доош хувьтай төлөвлөлт хийж чаддаг гэж хариулсан байна. Бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр гарсан үр дүнг дараах зургаас харна уу.


Зураг 13. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тээвэр, агуулахын салбарын хувьд бизнес эрхлэгчдийн 73.5 хувь нь өөрийн бизнест үйлдвэрлэлийн төлөвлөсөн тоог хэмжээг товлосон цагт нь 60-с дээш хувьтай үйлдвэрлэж чаддаг гэж хариулсан бол үлдсэн бизнес эрхлэгчид (26.5 хувь нь) 60-с доош хувьтай төлөвлөлт хийж чаддаг гэж хариулсан байна. Бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр гарсан үр дүнг дараах зургаас харна уу.

Зураг 14. Тээвэр, агуулахын салбарын бизнес эрхлэгчдийн өөрийн бизнесийн үйлдвэрлэлийн төлөвлөлтөд үнэлгээ өгсөн байдал



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн тухайн бизнес эрхлэгчдийн бизнес төлөвлөлтийн талаарх үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 12. Бизнес төлөвлөлт

Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид		
	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг бизнес эрхлэгчдийн эзлэх хувь	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг дундаж хугацаа, жилээр
Бүртгэлтэй	57.1%	2
Бүртгэлгүй	37.9%	1
Газар тариалангийн салбарын бизнес эрхлэгчид		
	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг бизнес эрхлэгчдийн эзлэх хувь	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг дундаж хугацаа, жилээр
Бүртгэлтэй	57.8%	2
Бүртгэлгүй	35.8%	2
Хүнсний боловсруулах салбарын бизнес эрхлэгчид		
	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг бизнес эрхлэгчдийн эзлэх хувь	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг дундаж хугацаа, жилээр
Бүртгэлтэй	63.8%	2
Бүртгэлгүй	26.3	1
Тээвэр, агуулахын салбарын бизнес эрхлэгчид		
	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг бизнес эрхлэгчдийн эзлэх хувь	Бизнес төлөвлөгөө боловсруулдаг дундаж хугацаа, жилээр
Бүртгэлтэй	45.7%	2
Бүртгэлгүй	23.5%	3

Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Б. Нөөцийн менежмент:** Нийт судалгаанд хамрагдсан 760 нэгжийн 65.5 хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг, бараа материал, нөөцийн захиалыг удирдлага шийддэг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн нөөцийг төрлөөр нь ангилах систем хөтөлдөггүй байна. Төлөвлөлт, менежменттэй холбоотойгоор:

- Бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой ашиглалтын зардал гардаг, түрээсийн зардал гардаггүй,
- Захиалгатай холбоотой зардал гардаг,
- Үйлдвэрлэлээс тасалдлаас шалтгаалсан зардал гардаггүй,
- Банкны албан ёсны данс бүртгэлтэй, өөрийн бизнесийн орлого, зарлагыг хөтөлж бүртгэдэг гэж нийтлэг хариулт өгсөн байна.

Зураг 15. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нөөцийн менежмент

Байршил / сонгох					
Баянхонгор аймаг / Баянхонгор			Дархан-Уул / Дархан		
Дорноговь / Сайншанд			Дорнод / Хэрлэн		
Завхан / Улиастай			Орхон / Баян-Өндөр		
Өвөрхангай / Арвайхээр			Өмнөговь / Даланзадгад		
Сэлэнгэ / Сүхбаатар			Улаанбаатар хот, орчмын бүс		
Ховд / Жаргалант			Хөвсгөл / Мөрөн		
Хэнтий / Хэрлэн					

Нөөцийн бүртгэлийн хөтлөлт		Бизнесийн шаардлагатай бараа материалын захиалгатай холбоотой шийдвэр гаргалт		Бизнесийн нөөцийг төрлөөр нь ангилах систем ашигладаг байдал			Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой ашиглалтын зардал гарсан эсэх			Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой гүрээсийн зардал гарсан эсэх			
Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	
498	262	1.1 Захирал	559	73.55%	188	541	31	446	307	7	236	523	1
65.5%	34.5%	1.2 Захирал болон менежер	80	10.53%	24.7%	71.2%	4.1%	58.7%	40.4%	0.9%	31.1%	68.8%	0.1%
Нийт		2.1 Менежер	55	7.24%	Нийт			Нийт			Нийт		
760		2.2 Менежер болон ажилт	8	1.05%	760			760			760		
		3. Ажилтан	32	4.21%									
		<b>Нийт</b>	<b>760</b>	<b>100.0%</b>									

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд захиалгатай холбоотой зардал гарсан эсэх			Өнгөрсөн 2 жилийн хугацаанд тасалдлаас шалтгаалсан зардал гарсан эсэх			Банжны бүртгэлтэй данстай эсэх		Бизнесийн орлого, зарлагыг хөтөцдөг эсэх	
Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
387	360	13	347	376	37	621	139	697	63
50.9%	47.4%	1.7%	45.7%	49.5%	4.9%	81.7%	18.3%	91.7%	8.3%
Нийт			Нийт			Нийт		Нийт	
760			760			760		760	

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх ерөнхий үр дүнг зорилтот салбар болон бүртгэлтэй эсэхээр задлан авч үзэж, үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 13. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн нөөцийн менежмент, зорилтот салбар болон бүртгэлтэй эсэхээр

Үзүүлэлт	Зорилтот салбар болон бүртгэлтэй эсэх							
	Мал аж ахуй		Газар тариалан		Хүнсний боловсруулах үйлдвэрлэл		Тээвэр, агуулах	
	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй
<b>1. Нөөцийн бүртгэл хөтөлдөг эсэх</b>								
Тийм	62.7%	62.1%	72.0%	41.8%	78.6%	42.1%	58.6%	29.4%
Үгүй	37.3%	37.9%	28.0%	58.2%	21.4%	57.9%	41.4%	70.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Энэхүү хүснэгтээс харахад бүх зорилтот салбаруудад бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь буюу 58.6%-78.6% нь нөөцийн бүртгэл хөтөлдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Харин бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд мал аж ахуйн салбараас бусад салбарын бизнес эрхлэгчдийн 57.9%-70.6% нь нөөцийн бүртгэл хөтөлдөггүй болох нь харагдаж байна.								
<b>2. Шаардлагатай БМ-ын захиалгын шийдвэр гаргалтыг хийдэг албан тушаалтан</b>								
Ажилтан	5.5%	3.4%	7.1%	12.0%	5.2%	4.6%	5.9%	0.0%
Захирал	72.1%	86.2%	64.4%	74.7%	61.5%	75.4%	60.8%	94.1%
Захирал болон ажилтан	2.7%	0.0%	3.9%	1.3%	2.8%	0.0%	1.0%	0.0%
Захирал болон менежер	6.8%	0.0%	8.7%	1.3%	11.6%	4.6%	14.7%	0.0%
Менежер	12.8%	10.3%	14.9%	8.0%	18.3%	13.8%	17.6%	5.9%
Менежер болон ажилтан	0.0%	0.0%	1.0%	2.7%	0.6%	1.5%	-	-
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Энэхүү хүснэгтээс шаардлагатай бараа материалын захиалгын шийдвэр гаргалтад салбар болон бүртгэлтэй эсэхээс үл хамааран нийтлэг Захирал албан тушаалтан шийдвэр гаргадаг нь харагдаж байна.								
<b>3. Бизнес нөөцийг төрлөөр нь ангилах системтэй эсэх</b>								
Үгүй	74.0%	75.9%	74.7%	83.6%	56.3%	84.2%	60.0%	88.2%
Тийм	23.2%	20.7%	21.8%	14.9%	41.9%	7.0%	27.1%	11.8%
Хариулж мэдэхгүй байна	2.8%	3.4%	3.6%	1.5%	1.7%	8.8%	12.9%	-
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Бүх зорилтот салбаруудад бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг хэдий ч нөөцийг төрлөөр ангилан бүртгэх нь учир дутагдалтай байгаа нь энэхүү хүснэгтээс харагдаж байна..								
<b>4. Бизнес өнгөрсөн 2 жилийн хугацаанд бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой ашиглалтын зардал гарсан эсэх</b>								
Үгүй	43.5%	48.3%	36.9%	56.7%	30.6%	50.9%	37.1%	47.1%
Тийм	55.9%	51.7%	62.2%	41.8%	69.4%	49.1%	60.0%	47.1%
Хариулж мэдэхгүй байна	0.6%	0.0%	0.9%	1.5%	0.0%	0.0%	2.9%	5.9%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
<b>5. Бизнес өнгөрсөн 2 жилийн хугацаанд бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой түрээсийн зардал гарсан эсэх</b>								
Үгүй	78.0%	82.8%	68.0%	74.6%	62.9%	71.9%	57.1%	76.5%
Тийм	22.0%	17.2%	32.0%	25.4%	37.1%	28.1%	41.4%	23.5%

Хариулж мэдэхгүй байна	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.4%	0.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Бүх зорилтот салбарын бизнес эрхлэгчдэд нийтлэг бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой ашиглалтын зардал гарч байна. Харин бүтээгдэхүүн хадгалалттай холбоотой түрээсийн зардал гарах нь бага байна. Энэ нь бүтээгдэхүүн хадгалалтыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан шийдвэрлэдэг болохыг илтгэж байна.

**6. Бизнес өнгөрсөн 2 жилийн хугацаанд захиалгатай холбоотой зардал гарсан эсэх**

Үгүй	46.3%	62.1%	48.4%	67.2%	33.2%	56.1%	51.4%	88.2%
Тийм	53.1%	37.9%	48.4%	32.8%	65.9%	43.9%	44.3%	11.8%
Хариулж мэдэхгүй байна	0.6%	0.0%	3.1%	0.0%	0.9%	0.0%	4.3%	0.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Мал аж ахуй болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдэд захиалгатай холбоотой зардал нийтлэг гарч байна.

**7. Бизнес өнгөрсөн 2 жилийн хугацаанд тасалдлаас шалтгаалсан зардал /хохирол/ гарсан эсэх**

Үгүй	55.9%	48.3%	51.1%	67.2%	40.2%	52.6%	27.1%	70.6%
Тийм	39.5%	48.3%	40.9%	29.9%	54.6%	45.6%	67.1%	29.4%
Хариулж мэдэхгүй байна	4.5%	3.4%	8.0%	3.0%	5.2%	1.8%	5.7%	0.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Тасалдлаас шалтгаалсан зардал /хохирол/ тээвэр, агуулах болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 54.6%-67.1%-д нь гарч байсан нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

**8. Бизнес банкны бүртгэлтэй данстай эсэх**

Тийм	94.9%	34.5%	95.1%	25.4%	95.2%	22.8%	94.3%	5.9%
Үгүй	5.1%	65.5%	4.9%	74.6%	4.8%	77.2%	5.7%	94.1%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

**9. Бизнес орлого, зарлагаа хөтөлдөг эсэх**

Тийм	92.7%	79.3%	94.7%	91.0%	96.5%	96.5%	90.0%	82.4%
Үгүй	7.3%	20.7%	5.3%	9.0%	3.5%	3.5%	10.0%	17.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Бүртгэлгүй бизнес эрхлэгчид нийтлэг байдал (65.5%-94.1% нь)-аар өөрийн хувийн данс ашиглан бизнесийнхээ төлбөр тооцоог хийдэг, мөн нийт бизнес эрхлэгчдийн 3.5%-20.7% нь бизнесийн орлого, зарлагын хөтлөлт хийдэггүй болох нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

### 3.1.4 Чанарын баталгаажуулалт

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу нийт 760 бизнес эрхлэгчээс 733 бизнес эрхлэгч өөрийн бизнест чанарын баталгаажуулалт, ISO нэвтрүүлэггүй байна. Олон улсын стандарт нэвтрүүлсэн 27 бизнес эрхлэгчийн 14 бизнес эрхлэгчид ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хүснэгт 14. Чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлт

Бизнест нэвтрүүлсэн стандарт	Бизнес эрхлэгчийн тоо	Эзлэх хувь
ISO 45001	4	0.5%
ISO 9001:2015	15	2.0%
ISO 14001:2015	8	1.1%
Нэвтрүүлээгүй	733	96.4%
<b>Нийт</b>	<b>760</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн энэ талын мэдээллийн олдоцтой байдлыг тодруулахад ихэнх хувь нь буюу 324 бизнес эрхлэгч энэ талын мэдээллийг хайдаггүй, энэ талын мэдээллийг судалж байгаа цөөнх бизнес эрхлэгчдийн хувьд энэ талын мэдээллийг олж авахад үнэ өртөг ихтэй гэж хариулсан байна.

Мөн дээрх ISO нэвтрүүлсэн 27 бизнес эрхлэгч бүгд бүртгэлтэй бизнес эрхлэгчид ба ISO 9001:2015 стандартыг газар тариалангийн салбарын 2 бизнес эрхлэгч, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 12 бизнес эрхлэгч, тээвэр, агуулахын салбарын нэг бизнес эрхлэгч, ISO14001:2015 стандартыг газар тариалангийн салбарын 2 бизнес эрхлэгч, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 6 бизнес эрхлэгч, ISO45001 стандартыг газар тариалангийн салбарын нэг бизнес эрхлэгч, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 3 бизнес эрхлэгч тус тус нэвтрүүлээд байна.

### 3.1.5 Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа ба өөрчлөлтийн бэлэн байдал

А. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа: Судалгаанд хамрагдсан нийт 760 бизнес эрхлэгчдийн 3.3 хувь нь өөрийн бизнес вэб хуудастай, мөн нийт бизнес эрхлэгчдийн 31.5 хувь нь өөрийн бизнест фэйсбүүк хуудас ашигладаг гэж хариулсан байна.

Мөн харилцагч, худалдан авагчдад өөрийн бизнесийг танилцуулахад:

- Давхардсан тоогоор нийт бизнесийн эрхлэгчдийн 6.2 хувь нь телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг, 1.8 хувь нь сонин, сэтгүүл ашигладаг, 47.1 хувь нь олон нийтийн сүлжээ ашигладаг, 80.9 хувь нь танил тал, найз нөхдөөр дамжуулдаг, 41.1 хувь нь үзэсгэлэн худалдаа ашиглан харилцагч, худалдан авагчдад бизнесээ танилцуулдаг байна.
- Энэдээс харахад өөрийн бизнесийг бусдад танилцуулах гол суваг нь олон нийтийн сүлжээ болон танил тал, найз нөхөд болдог байна.

Зорилтот салбар болон бүртгэлтэй эсэхээр энэхүү үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 15. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа 1

1.1 Мал аж ахуйн салбарын бүртгэлтэй нийт 177 бизнес эрхлэгчдийн хувьд:	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	2.8%	97.2%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	29.9%	70.1%

<b>Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:</b>		
Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	6.2%	93.8%
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	1.7%	98.3%
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	42.9%	57.1%
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	83.1%	16.9%
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	28.8%	71.2%

### **1.2 Мал аж ахуйн салбарын бүртгэлгүй нийт 29 бизнес эрхлэгчдийн хувьд:**

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	-	100.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	17.2%	82.8%

### **Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:**

Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	6.9%	93.1%
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	-	100.0%
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	41.4%	58.6%
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	86.2%	13.8%
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	31.0%	69.0%

Дүгнэлт: Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа болон олон нийтийн сүлжээ байна.

### **2.1 Газар тариалангийн салбарын бүртгэлтэй нийт 225 бизнес эрхлэгчдийн хувьд:**

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	3.6%	93.8%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	28.4%	71.6%

### **Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:**

Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	6.2% нь ашигладаг
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	1.3% нь ашигладаг
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	44.0% нь ашигладаг
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	82.7% нь ашигладаг
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	47.1% нь ашигладаг

### **2.2 Газар тариалангийн салбарын бүртгэлгүй нийт 67 бизнес эрхлэгчдийн хувьд:**

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	-	100.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	14.9%	85.1%

### **Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:**

Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	1.5% нь ашигладаг
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	3.0% нь ашигладаг
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	46.3% нь ашигладаг
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	89.6% нь ашигладаг
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	40.3% нь ашигладаг

Дүгнэлт: Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа, үзэсгэлэн худалдаа болон олон нийтийн сүлжээ байна.

### **3.1 Хүнсний боловсруулах салбарын бүртгэлтэй нийт 229 бизнес эрхлэгчдийн хувьд:**

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	7.0%	93.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	45.0%	55.0%

### **Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:**

Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	9.6% нь ашигладаг
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	2.6% нь ашигладаг



Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	55.5% нь ашигладаг
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	71.6% нь ашигладаг
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	54.6% нь ашигладаг

### 3.2 Хүнсний боловсруулах салбарын бүртгэлгүй нийт 57 бизнес эрхлэгчдийн хувьд:

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	-	100.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	31.6%	68.4%
<b>Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:</b>		
Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	1.8% нь ашигладаг	
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	3.5% нь ашигладаг	
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	31.6% нь ашигладаг	
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	84.2% нь ашигладаг	
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	40.4% нь ашигладаг	

Дүгнэлт: Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа, үзэсгэлэн худалдаа болон олон нийтийн сүлжээ байна.

### 4.1 Тээвэр, агуулахын салбарын бүртгэлтэй нийт 70 бизнес эрхлэгчдийн хувьд:

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	-	100.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	28.6%	71.4%
<b>Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:</b>		
Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	4.3% нь ашигладаг	
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	Ашигладаггүй	
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	58.6% нь ашигладаг	
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	85.7% нь ашигладаг	
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	17.1% нь ашигладаг	

### 4.2 Тээвэр, агуулахын салбарын бүртгэлгүй нийт 17 бизнес эрхлэгчдийн хувьд:

	Тийм	Үгүй
Бизнес өөрийн вэб хуудастай эсэх	-	100.0%
Бизнес өөрийн фэйсбүүк хуудастай эсэх	5.9%	94.1%
<b>Өөрийн бизнесийг харилцагч, худалдан авагчдад танилцуулахад ашигладаг суваг:</b>		
Телевиз, радиогийн зар сурталчилгаа ашигладаг эсэх	Ашигладаггүй	
Сонин, сэтгүүл ашигладаг эсэх	Ашигладаггүй	
Олон нийтийн сүлжээ ашигладаг эсэх	35.3% нь ашигладаг	
Танил тал, найз нөхдөөр дамжуулан танилцуулдаг эсэх	88.2% нь ашигладаг	
Үзэсгэлэн худалдаа ашигладаг эсэх	29.4% нь ашигладаг	

Дүгнэлт: Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа болон олон нийтийн сүлжээ байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Харин нийт 760 бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн биеэр очиж уулзан холбоо тогтоодог гэж 82.4 хувь нь, албан ёсны хурал семинар дээр холбоо тогтоодог гэж 19.3 хувь нь, үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр уулзаж холбоо тогтоодог гэж 37.1 хувь нь, бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан холбоо тогтоодог гэж 43.9 хувь нь, олон нийтийн сүлжээ ашиглаж холбоо тогтоодог гэж 40.5 хувь нь тус тус хариулсан байна. Зорилтот салбар болон бүртгэлтэй, бүртгэлгүй бизнес эрхлэгчдээр зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй хэрхэн холбоо тогтоож байгааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 16. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа 2

<b>1.1 Мал аж ахуйн салбарын бүртгэлтэй нийт 177 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	84.7%
Албан ёсны хурал, семинар дээр	23.7%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	27.1%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	42.9%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	33.9%
<b>1.2 Мал аж ахуйн салбарын бүртгэлгүй нийт 29 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	79.3%
Албан ёсны хурал, семинар дээр	13.8%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	20.7%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	44.8%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	51.7%
Дүгнэлт: Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.	
<b>2.1 Газар тариалангийн салбарын бүртгэлтэй нийт 225 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	80.4%
Албан ёсны хурал, семинар дээр	20.0%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	45.3%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	44.0%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	44.0%
<b>2.2 Газар тариалангийн салбарын бүртгэлгүй нийт 67 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	88.1%
Албан ёсны хурал, семинар дээр	7.5%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	32.8%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	35.8%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	47.8%
Дүгнэлт: Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.	
<b>3.1 Хүнсний боловсруулах салбарын бүртгэлтэй нийт 229 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	78.6%
Албан ёсны хурал, семинар дээр	24.9%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	46.7%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	45.9%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	43.7%
<b>3.2 Хүнсний боловсруулах салбарын бүртгэлгүй нийт 57 бизнес эрхлэгчдийн хувьд:</b>	
<b>Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:</b>	
Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	80.7%
Албан ёсны хурал, семинар дээр	7.0%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	31.6%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	40.4%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	29.8%

Дүгнэлт: Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.

#### 4.1 Тээвэр, агуулахын салбарын бүртгэлтэй нийт 70 бизнес эрхлэгчдийн хувьд:

Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:

Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	90.0%
Албан ёсны хурал, семинар дээр	15.7%
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	21.4%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	51.4%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	47.1%

#### 4.2 Тээвэр, агуулахын салбарын бүртгэлгүй нийт 17 бизнес эрхлэгчдийн хувьд:

Зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог суваг:


Өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог	94.1%
Албан ёсны хурал, семинар дээр	-
Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээн дээр	29.4%
Бизнесийн хамтрагч талуудаар дамжуулан	35.3%
Олон нийтийн сүлжээ ашигладаг	35.3%

Дүгнэлт: Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна. Бусад салбаруудтай харьцуулахад энэхүү хэлбэрээр холбоо тогтоох байдал нь илүү өндөр хувьтай байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Мөн бусад оролцогч талуудтай хэрхэн холбоо тогтгож байгааг дараах зургаас харна уу.

Зураг 16. Бизнесийн харилцаа, хамтын ажиллагаа\_3



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх зургаас харахад бусад оролцогч талуудтай холбоо тогтоох нийтлэг арга нь өөрийн биеэр очиж уулзах явдал байна.


Мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага/мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа, үр өгөөжийг авч үзэхэд:

- Нийт бизнес эрхлэгчдийн 8.0 хувь нь орон нутгийн захиргаанаас үзүүлж буй татварын хөнгөлөлтт, урамшууллын үйлчилгээнд хамрагддаг, 26.9 хувь нь төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн үйлчилгээнд, 26.2 хувь нь мэргэжлийн туслалцаа/зөвлөх үйлчилгээнд, 39.2 хувь нь дээрх бусад төрлийн үйлчилгээнд хамрагддаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Мөн нийт бизнес эрхлэгчдийн 15.5 хувь нь орон нутгийн төрийн бус байгууллага/мэргэжлийн холбоотой байнга хамтран ажилладаг, 31.6 хувь нь заримдаа хамтран ажилладаг, 49.6 хувь нь хамтран ажилладаггүй, 3.3 хувь нь энэ чиглэлийн байгууллага орон нутагт байхгүй гэж хариулсан байна. Зорилтот салбар болон бүртгэлгүй эсэх гэсэн шинж тэмдгээр гарсан үр дүнг хавсралтаас харна уу.

**Б. Өөрчлөлтийн бэлэн байдал:** Нийт судалгаанд хамрагдсан 760 бизнес эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг давхардсан тоогоор авч үзэхэд:

- Нийтлэг санхүүгийн, техник, тоног төхөөрөмжийн болон хүний нөөцийн хэрэгцээ шаардлага үүсээд байгаа нь судалгаанаас харагдсан.

Зураг 17. Бизнесийн хэрэгцээ, шаардлага



Эх сурвалж: Судалгааны үр дүн

- Санхүү маш их шаардлагай байна гэж нийт 760 бизнес эрхлэгчдийн 46 орчим хувь нь, ойрын хугацаанд зээл авахаар төлөвлөж буй нийт 575 бизнес эрхлэгч байгаа бөгөөд нэг бизнес эрхлэгч дунджаар 223.7 сая төгрөгийн санхүүгийн хэрэгцээ байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд ихэвчлэн банкинд ханддаг (давхардсан тоогоор нийт 520 бизнес эрхлэгч); мөн орон нутгийн сангууд (331 бизнес эрхлэгч) болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдэд (110 бизнес эрхлэгч) санхүүжилт авахаар хандаж байсан байна.
- Харин хүний нөөцтэй холбоотой:

- Нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал нь тогтвор суурьшилтай ажилладаггүй гэж бизнес эрхлэгчид үзэж байна. Харин ажиллагсдын мэргэжил, ур чадвар хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна.

<i>Тулгамдаж буй асуудал</i>	<i>Тулгамдаж буй асуудал гэж үзсэн бизнес эрхлэгчдийн тоо</i>
<i>Тогтвор суурьшилтай ажилладаггүй</i>	429
<i>Ажиллах хүч олддоггүй</i>	326
<i>Цалингийн түвшин хангалтгүй</i>	276
<i>Мэргэжил, боловсролын хувьд хангалтгүй</i>	176
<i>Ур чадварын хувьд тэнцдэггүй</i>	164

- Дээрх тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх гол арга зам нь:

<i>Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам</i>	<i>Арга зам гэж үзсэн бизнес эрхлэгчдийн тоо</i>
<i>Цалин, урамиуулал нэмэгдүүлэх</i>	441
<i>Ажлын байрны ажиллах орчныг сайжруулах</i>	322
<i>Мэргэжлийн, ур чадварын сургалт явуулах</i>	273
<i>Нийгмийн хангамжийг дээшлүүлэх</i>	202
<i>Бусад орон нутгаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах</i>	65
<i>Гадаадаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах</i>	11

гэж үзсэн байна. Хүснэгтээс харахад асуудал болгонд чиглэсэн шийдвэрлэх арга зам харж байгаа нь мэдэгдэж байна. Мөн өөрийн орон нутгаас шаардлага хангасан хүний нөөц авах боломжтой гэж ихэнх (шаардлага хангасан хангалттай нөөцтэй гэж 54.3 хувь нь үзсэн) бизнес эрхлэгчид харж байна. Гэхдээ өөрийн бизнес ажил горилогч ажилд нийтлэг тухайн хүний зөөлөн ур чадварыг чухалчилдаг гэж 643 бизнес эрхлэгч үзэж байна.

- Хэдийгээр ажил олгогч байгууллагаас ажил горилогчийн зөөлөн ур чадварыг илүүд чухалчилан үзэж (366 бизнес эрхлэгч энэ сонголтыг хийсэн), харин ажил горилогч талаас байгууллагын цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж (360 бизнес эрхлэгч энэ сонголтыг хийсэн), бизнес эрхлэгч болон ажил горилогч хооронд зөрүүтэй байдал үүсдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

- Энэхүү зөрүүтэй байдлыг арилгахад:

<i>Шаардлагатай тусламж, дэмжлэг</i>	<i>Шийдэх арга зам гэж үзсэн бизнес эрхлэгчдийн тоо</i>
<i>Санхүүгийн тусалцаа авах</i>	463
<i>Ажил горилогчыг чадавхжуулах сургалт явуулах</i>	383
<i>Мэргэжлийн тусалцаа/зөвлөх үйлчилгээ авах</i>	324

Дээрх үр дүнг зорилтот салбар, бүртгэлтэй эсэх гэсэн шинж тэмдгээр задлан харуулсан үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 17. Бизнесийн хэрэгцээ, шаардлага зорилтот

Зорилтот салбар	Бүртгэлтэй эсэх	Зайлиггүй шаардлагатай, тулгарч буй хэрэгцээ							
		Санхуу	Хүний нөөц	Техник, тоног төхөөрөмж	Эрсдлийн удирдлага нэвтрүүлэх	Тээвэр, логистик сайжруулах	Бизнесээ тогтвортой явуулах	Мэдээллийн технологи	Мэргэжлийн зөвлөгөө/туслалцаа авах хэрэгцээ
Мал аж ахуй	Бүртгэлтэй	80.2%	32.8%	60.5%	4.0%	17.5%	14.7%	6.8%	32.8%
	Бүртгэлгүй	89.7%	20.7%	51.7%	13.8%	6.9%	20.7%	10.3%	41.4%
Газар тариалан	Бүртгэлтэй	82.7%	36.9%	68.0%	7.1%	17.3%	20.4%	3.1%	27.6%
	Бүртгэлгүй	86.6%	32.8%	73.1%	4.5%	3.0%	16.4%	3.0%	22.4%
Хүнсний боловсруулах	Бүртгэлтэй	88.2%	43.2%	58.5%	7.0%	16.6%	28.4%	7.9%	29.7%
	Бүртгэлгүй	82.5%	28.1%	70.2%	1.8%	10.5%	28.1%	3.5%	26.3%
Тээвэр, агуулах	Бүртгэлтэй	80.0%	37.1%	58.6%	2.9%	22.9%	17.1%	5.7%	24.3%
	Бүртгэлгүй	82.4%	23.5%	64.7%	5.9%	17.6%	11.8%	5.9%	11.8%

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх хүснэгтээс харахад бүх зорилтот салбарын бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн их шаардлагатай хэрэгцээнд санхүүгийн хэрэгцээ багтаж байна. Жишээ нь мал аж ахуйн салбарын бүртгэлтэй нийт 177 бизнес эрхлэгчдийн 80.2 хувь нь санхүүгийн хэрэгцээ шаардлага үүсээд байна гэж хариулсан байна.

Ийнхүү нэн тэргүүнд үүсээд буй санхүүгийн хэрэгцээ хэр зэрэг шаардлагатай байгаа болон ойрын хугацаанд төлөвлөсөн үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 18. Санхүүгийн хэрэгцээ, шаардлага 1

Үзүүлэлт	Мал аж ахуй		Газар тариалан		Хүнсний боловсруулах		Тээвэр, агуулах		Дундаж
	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	Бүртгэлтэй	Бүртгэлгүй	
<b>Санхүүгийн хэрэгцээ хэр зэрэг үүсэж байгаа талаар:</b>									
Мал их шаардлагатай	48.6%	41.4%	50.2%	43.3%	45.0%	45.6%	40.0%	35.3%	43.7%
Шаардлагатай	44.1%	44.8%	40.4%	52.2%	45.9%	40.4%	42.9%	52.9%	45.4%
Бага зэрэг шаардлага	5.1%	13.8%	7.6%	3.0%	7.9%	14.0%	10.0%	5.9%	8.4%
Шаардлагагүй	2.3%	-	1.8%	1.5%	1.3%	-	7.1%	5.9%	2.5%
Нийт дүн	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%


<b>Ойрын хугацаанд зээл авахаар төлөвлөж байгаа эсэх:</b>									
Тийм	74.0%	79.3%	78.7%	80.6%	75.1%	84.2%	74.3%	70.6%	77.1%
Үгүй	26.0%	20.7%	21.3%	19.4%	24.9%	15.8%	25.7%	29.4%	22.9%
<b>Хэрэв тийм бол авахаар төлөвлөж буй зээлийн дүн, сая төгрөг</b>									
	154.0	95.5	341.8	79.7	396.9	56.6	224.3	96.1	180.6

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх хүснэгтээс харахад нийт бизнес эрхлэгчдийн 88.1 хувь нь санхүүгийн хэрэгцээ маш их болон шаардлагатай байгаа, мөн 77.1 хувь нь ойрын хугацаанд зээл авахаар төлөвлөж байгаа бөгөөд дунджаар 180.6 сая төгрөгийн санхүүгийн хэрэгцээ шаардлагатай байгаа гэсэн судалгааны үр дүн гарч байна.

Мөн өмнө нь зээлийн санхүүжилт авахаар хаана хандаж байсныг дараах зургаар харуулав.

Зураг 18. Санхүүгийн хэрэгцээ, шаардлага\_2



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх зургаас судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчид зээлийн санхүүжилт авахаар нэн тэргүүнд арилжааны банкинд, үүний дараагаар төрийн болон орон нутгийн сангуудад ханддаг нь харагдаж байна.

**Нэг. Мал аж ахуйн салбарт** үйл ажиллагаа эрхэлж буй нийт 206 бизнес эрхлэгчид (давхардсан тоогоор)-ийн хувьд хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам зэргийг багтаасан судалгааны үр дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 19. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага Мал аж ахуйн салбар

Бизнес эрхлэгчид	Нэг. Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудал				
	Мэргэжил, боловсролын хувьд хангалтгүй	Ур чадварын хувьд тэнцдэггүй	Тогтвор суурьшилтай ажилладаггүй	Ажиллах хүч олдоогүй	Цалингийн түвшин хангалтгүй
Бүртгэлтэй	27.1%	18.6%	48.6%	42.4%	33.3%
Бүртгэлгүй	13.8%	27.6%	75.9%	37.9%	20.7%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч нэг талаас тогтвор суурьшилтай ажилладаггүй, нөгөө талаас ажиллах хүч олдоогүй гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгчид	Хоёр. Шийдвэрлэх арга зам					
	Мэргэжлийн, ур чадварын сургалт	Цалин, урамшуулал нэмэгдүүлэх	Нийгмийн хангамжийг дээшлүүлэх	Ажиллах орчныг сайжруулах	Гадаадаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах	Бусад орон нутгаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах
Бүртгэлтэй	37.3%	46.3%	24.3%	45.2%	1.7%	11.3%
Бүртгэлгүй	27.6%	48.3%	17.2%	48.3%	0.0%	6.9%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь цалин, урамшуулал нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах болон мэргэжил, ур чадварын сургалт явуулах гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгчид	Гурав. Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас тавигддаг гол шаардлага, ур чадвар			
	Зөвлөн ур чадвар	Мэргэжлийн ур чадвар	Бусад ур чадвар	
Бүртгэлтэй		81.4%	49.7%	11.3%
Бүртгэлгүй		89.7%	17.2%	3.4%

Дүгнэлт: Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөвлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн



Бизнес эрхлэгчид	Дөрөв. Ажил горилогч болон ажил олгогч хоорондын нийцгүй байдал				
	Ажил горилогч нь байгууллагаас тавьсан		Ажил горилогч нь		
	Мэргэжлийн ур чадварт нийцдэггүй	Зөөлөн ур чадварт нийцдэггүй	Бусад шаардлагад нийцдэггүй	Цалингийн түвшин хангалтгүй гэж үздэг	Ажиллах орчин, нийгмийн дэмжлэг хангалтгүй гэж үздэг
Бүртгэлтэй	31.6%	40.7%	6.8%	51.4%	24.9%
Бүртгэлгүй	13.8%	48.3%	17.2%	37.9%	27.6%

Дүгнэлт: Ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна.

Бизнес эрхлэгчид	Тав. Хүний нөөцийн зөрүүтэй байдлыг арилгах арга зам / бусад оролцогч талуудаас хүсч буй дэмжлэг			
	Зөвлөх үйлчилгээ авах	Санхүүгийн туслалцаа авах	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт явуулах	Бусад туслалцаа авах
Бүртгэлтэй	41.8%	56.5%	53.1%	7.3%
Бүртгэлгүй	48.3%	58.6%	34.5%	6.9%

Дүгнэлт: Ажил горилогч болон ажил олгогч талуудын хоорондын зөрүүтэй байдлыг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах нь гол арга зам гэдэг нь энэхүү хүснэгтээс харагдаж байна.

Бизнес эрхлэгчид	Хангалттай нөөцтэй	Хангалттай нөөц байхгүй	Тухайн мэргэжлийн нөөц байхгүй
Бүртгэлтэй	46.9%	35.0%	18.1%
Бүртгэлгүй	51.7%	44.8%	3.4%

Дүгнэлт: Орон нутагт тухайн мэргэжлийн хангалттай нөөцтэй гэж дийлэнх бизнес эрхлэгчид үзэж байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Хоёр. Газар тариалангийн салбарт** үйл ажиллагаа эрхэлж буй нийт 292 бизнес эрхлэгчид (давхардсан тоогоор)-ийн хувьд хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам зэргийг багтаасан судалгааны үр дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 20. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага Газар тариалангийн салбар

Бизнес эрхлэгч	Нэг. Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудал				
	Мэргэжил, боловсролын хувьд хангалтгүй	Ур чадварын хувьд тэнцдэггүй	Тогтвор суурьшилтай ажилладаггүй	Ажиллах хүч олддоггүй	Цалингийн түвшин хангалтгүй
Бүртгэлтэй	26.7%	22.2%	46.7%	48.9%	44.4%
Бүртгэлгүй	10.4%	10.4%	49.3%	52.2%	47.8%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч нэг талаас тогтвор суурьшилтай ажилладаггүй, нөгөө талаас ажиллах хүч олдоггүй, мөн цалингийн түвшин хангалтгүй гээд ажилладаггүй гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Хоёр. Шийдвэрлэх арга зам					
	Мэргэжлийн, ур чадварын сургалт	Цалин, урамшуулал нэмэгдүүлэх	Нийгмийн хангамжийг дээшлүүлэх	Ажиллах орчны сайжруулах	Гадаадаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах	Бусад орон нутгаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах
Бүртгэлтэй	39.6%	64.9%	28.9%	40.0%	2.7%	10.7%
Бүртгэлгүй	19.4%	61.2%	23.9%	35.8%	1.5%	10.4%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь цалин, урамшуулал нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах болон мэргэжил, ур чадварын сургалт явуулах гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Гурав. Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас тавигддаг гол шаардлага, ур чадвар		
	Зөөлөн ур чадвар	Мэргэжлийн ур чадвар	Бусад ур чадвар
Бүртгэлтэй	82.2%	53.3%	7.6%
Бүртгэлгүй	92.5%	26.9%	11.9%

Дүгнэлт: Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Дөрөв. Ажил горилогч болон ажил олгогч хоорондын нийцгүй байдал				
	Ажил горилогч нь байгууллагаас тавьсан			Ажил горилогч нь	
	Мэргэжлийн ур чадварт нийцдэггүй	Зөөлөн ур чадварт нийцдэггүй	Бусад шаардлагад нийцдэггүй	Цалингийн түвшин хангалтгүй гэж үздэг	Ажиллах орчин, нийгмийн дэмжлэг хангалтгүй гэж үздэг
Бүртгэлтэй	35.6%	41.3%	5.3%	52.4%	25.3%
Бүртгэлгүй	16.4%	53.7%	4.5%	53.7%	23.9%

Дүгнэлт: Ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна.

Бизнес эрхлэгчид	Тав. Хүний нөөцийн зөрүүтэй байдлыг арилгах арга зам / бусад оролцогч талуудаас хүсч буй дэмжлэг			
	Зөвлөх үйлчилгээ авах	Санхүүгийн туслалцаа авах	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт явуулах	Бусад туслалцаа авах
Бүртгэлтэй	48.4%	64.4%	48.0%	4.9%
Бүртгэлгүй	32.8%	70.1%	41.8%	3.0%

Дүгнэлт: Ажил горилоч болон ажил олгогч талуудын хоорондын зөрүүтэй байдлыг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилочдыг чадавхжуулах сургалт явуулах, мөн ажил олгогч талаас мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй гэж үзсэн байна.

Бизнес эрхлэгчид	Хангалттай нөөцтэй	Хангалттай нөөц байхгүй	Тухайн мэргэжлийн нөөц байхгүй
Бүртгэлтэй	51.1%	38.7%	10.2%
Бүртгэлгүй	61.2%	37.3%	1.5%

Дүгнэлт: Орон нутагт тухайн мэргэжлийн хангалттай нөөцтэй гэж 50 гаруй хувь нь үзэж байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Гурав. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт** үйл ажиллагаа эрхэлж буй нийт 286 бизнес эрхлэгчид (давхардсан тоогоор)-ийн хувьд хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам зэргийг багтаасан судалгааны үр дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 21. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага\_Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбар

Бизнес эрхлэгч	Нэг. Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудал				
	Мэргэжил, боловсролын хувьд хангалтгүй	Ур чадварын хувьд тэнцдэггүй	Тогтвор суурьшилтай ажилладаггүй	Ажиллах хүч олддоггүй	Цалингийн түвшин хангалтгүй
Бүртгэлтэй	29.3%	30.1%	63.8%	40.2%	36.7%
Бүртгэлгүй	19.3%	24.6%	66.7%	36.8%	31.6%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Хоёр. Шийдвэрлэх арга зам					
	Мэргэжлийн, ур чадварын сургалт	Цалин, урамиуулал нэмэгдүүлэх	Нийгмийн хангамжийг дээшлүүлэх	Ажиллах орчны сайжруулах	Гадаадаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах	Бусад орон нутгаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах
Бүртгэлтэй	43.7%	63.8%	32.8%	41.0%	0.9%	9.2%
Бүртгэлгүй	26.3%	54.4%	24.6%	56.1%	0.0%	1.8%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь цалин, урамиуулал нэмэгдүүлэх гэсэн үр дүн харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Гурав. Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас тавигддаг гол шаардлага, ур чадвар		
	Зөөлөн ур чадвар	Мэргэжлийн ур чадвар	Бусад ур чадвар
Бүртгэлтэй	87.8%	40.6%	9.2%
Бүртгэлгүй	86.0%	26.3%	17.5%

Дүгнэлт: Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Дөрөв. Ажил горилогч болон ажил олгогч хоорондын нийцгүй байдал				
	Ажил горилогч нь байгууллагаас тавьсан			Ажил горилогч нь	
	Мэргэжлийн ур чадварт нийцдэггүй	Зөөлөн ур чадварт нийцдэггүй	Бусад шаардлагад нийцдэггүй	Цалингийн түвшин хангалтгүй гэж үздэг	Ажиллах орчин, нийгмийн дэмжлэг хангалтгүй гэж үздэг
Бүртгэлтэй	34.9%	61.1%	8.7%	42.8%	20.1%
Бүртгэлгүй	21.1%	57.9%	1.8%	45.6%	15.8%

Дүгнэлт: Ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна.

Бизнес эрхлэгчид	Тав. Хүний нөөцийн зөрүүтэй байдлыг арилгах арга зам / бусад оролцогч талуудаас хүсч буй дэмжлэг			
	Зөвлөх үйлчилгээ авах	Санхүүгийн туслалцаа авах	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт явуулах	Бусад туслалцаа авах
Бүртгэлтэй	45.4%	60.7%	58.1%	6.6%
Бүртгэлгүй	40.4%	70.2%	38.6%	5.3%

Дүгнэлт: Ажил горилогч болон ажил олгогч талуудын хоорондын зөрүүтэй байдлыг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах, мөн ажил олгогч талаас мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй гэж үзсэн байна.

Бизнес эрхлэгчид	Хангалттай нөөцтэй	Хангалттай нөөц байхгүй	Тухайн мэргэжлийн нөөц байхгүй
Бүртгэлтэй	54.1%	29.7%	16.2%
Бүртгэлгүй	68.4%	24.6%	7.0%

Дүгнэлт: Орон нутагт тухайн мэргэжлийн хангалттай нөөцтэй гэж 54.1-68.4 хувь нь үзэж байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Дөрөв. Тээвэр, агуулахын салбарт** үйл ажиллагаа эрхэлж буй нийт 87 бизнес эрхлэгчид (давхардсан тоогоор)-ийн хувьд хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам зэргийг багтаасан судалгааны үр дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 22. Хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага\_Тээвэр, агуулахын салбар

Бизнес эрхлэгч	Нэг. Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудал				
	Мэргэжил, боловсролын хувьд хангалтгүй	Ур чадварын хувьд тэнцдэггүй	Тогтвор суурьшилтай ажилладаггүй	Ажиллах хүч олддоггүй	Цалингийн түвшин хангалтгүй
Бүртгэлтэй	21.4%	24.3%	68.6%	28.6%	37.1%
Бүртгэлгүй	11.8%	11.8%	52.9%	35.3%	47.1%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй гэсэн үр дүн бусад салбаруудтай мөн адил ажиглагдаж байна.

Бизнес эрхлэгч	Хоёр. Шийдвэрлэх арга зам					
	Мэргэжлийн, ур чадварын сургалт	Цалин, урамшуулал нэмэгдүүлэх	Нийгмийн хангамжийг дээшлүүлэх	Ажиллах орчны сайжруулах	Гадаадаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах	Бусад орон нутгаас чадварлаг ажиллах хүчнийг ажиллуулах
Бүртгэлтэй	32.9%	57.1%	32.9%	45.7%	1.4%	4.3%
Бүртгэлгүй	11.8%	52.9%	17.6%	52.9%	0.0%	11.8%

Дүгнэлт: Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь цалин, урамшуулал нэмэгдүүлэх болон ажиллах орчныг сайжруулах гэсэн үр дүн харагдаж байна. Энэ нь 100 хувь ажил олгогч байгууллагаас хамааралтай шийдвэрлэх арга зам байна.

Бизнес эрхлэгч	Гурав. Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас тавигддаг гол шаардлага, ур чадвар		
	Зөөлөн ур чадвар	Мэргэжлийн ур чадвар	Бусад ур чадвар
Бүртгэлтэй	82.9%	48.6%	11.4%
Бүртгэлгүй	88.2%	29.4%	11.8%

Дүгнэлт: Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна.

Бизнес эрхлэгч	Дөрөв. Ажил горилогч болон ажил олгогч хоорондын нийцгүй байдал				
	Ажил горилогч нь байгууллагаас тавьсан			Ажил горилогчид байгууллагаас санал болгосон	
	Мэргэжлийн ур чадварт нийцдэггүй	Зөөлөн ур чадварт нийцдэггүй	Бусад шаардлагад нийцдэггүй	Цалингийн түвшин хангалтгүй гэж үздэг	Ажиллах орчин, нийгмийн дэмжлэг хангалтгүй гэж үздэг
Бүртгэлтэй	32.9%	47.1%	4.3%	50.0%	24.3%
Бүртгэлгүй	17.6%	41.2%	11.8%	64.7%	23.5%

Дүгнэлт: Ажил олгогч талаас шаарддаг мэргэжлийн болон зөөлөн ур чадвар, нөгөө талаас ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна.

Бизнес эрхлэгчид	Тав. Хүний нөөцийн зөрүүтэй байдлыг арилгах арга зам / бусад оролцогч талуудаас хүсч буй дэмжлэг			
	Зөвлөх үйлчилгээ авах	Санхүүгийн туслалцаа авах	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт явуулах	Бусад туслалцаа авах
Бүртгэлтэй	38.6%	58.6%	55.7%	7.1%
Бүртгэлгүй	17.6%	58.8%	47.1%	5.9%

Дүгнэлт: Ажил горилогч болон ажил олгогч талуудын хоорондын зөрүүтэй байдлыг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах нь зүйтэй гэж бизнес эрхлэгчид үзсэн байна.

Бизнес эрхлэгчид	Хангалттай нөөцтэй	Хангалттай нөөц байхгүй	Тухайн мэргэжлийн нөөц байхгүй
Бүртгэлтэй	58.6%	34.3%	7.1%
Бүртгэлгүй	64.7%	23.5%	11.8%

Дүгнэлт: Орон нутагт тухайн мэргэжлийн хангалттай нөөцтэй гэж 59-65 орчим хувь нь үзэж байна.

Эх сурвалж: Судалгааны үр дүн

### 3.1.6 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдал

Судалгаанд хамрагдсан нийт 760 бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь буюу 597 бизнес эрхлэгч байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт өөрийн бизнест эрсдэл учруулж байна гэж үзсэн ба эдгээр 597 бизнес эрхлэгчийн 91 хувь нь маш их болон их эрсдэл учруулж байна, 8.2 хувь дундаас доош хэмжээнд эрсдэлд учруулж байна гэж үзсэн байна. Энэхүү үр дүнг зорилтот салбараар авч үзэж, судалгааны үр дүнг дараах байдлаар тодорхойлов.

	Мал аж ахуй	Газар тариалан	Хүнсний боловсруулах үйлдвэрлэл	Тээвэр, агуулах болон дундын ...
1. Уур амьсгалын өөрчлөлт өөрийн бизнест эрсдэл учруулж байна гэж үзсэн бизнес эрхлэгчдийн эзлэх хувь	100.0%	100.0%	100.0%	100.0%
2. Хэрэв тийм бол бизнест хэр зэрэг эрсдэл учруулж байгаа талаар:				
Маш их эрсдэл учруулж байна	86.9%	91.8%	68.2%	70.1%
Их эрсдэл учруулж байна	8.3%	4.5%	22.0%	20.7%
Дунд зэрэг эрсдэл учруулж байна	0.0%	0.7%	0.3%	2.3%
Бага эрсдэл учруулж байна	1.9%	0.7%	3.8%	2.3%
Маш бага эрсдэл учруулж байна	2.9%	2.4%	5.6%	4.6%
3. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бизнест хамгийн их эрсдэл учруулж байгаа хүчин зүйлс:			Хүнсний боловсруулах үйлдвэрлэл	Тээвэр, агуулах
Байгалийн нөөцийн хомсдол хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан	50.0%	52.1%	31.5%	27.6%
Цөлжилт хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан	23.3%	24.3%	17.8%	9.2%
Ган, зуд хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан	52.4%	49.3%	37.4%	28.7%

<i>Түүхий эд, материалын хомсдол хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан</i>	15.0%	11.6%	35.0%	25.3%
<i>Цаг агаарын эрс тэс байдал хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан</i>	59.2%	63.0%	28.0%	41.4%
<i>Бусад хүчин зүйлс хамгийн их эрсдэл учруулж байна гэж хариулсан</i>	9.7%	13.0%	7.3%	9.2%
<i>Уур амьсгалын өөрчлөлтийг өөрийн бизнест боломж гэж харуулсан:</i>				
<i>Нийт бизнес эрхлэгчдийн</i>	68.0%	74.7%	61.5%	47.1%
<i>Боломж гэж хариулсан бизнес эрхлэгчдийн хувьд:</i>				
<i>Уур амьсгалын өөрчлөлтийг шинэ техник, технологи нэвтрүүлэх боломж гэж харуулсан</i>	62.9%	72.5%	65.9%	65.9%
<i>Уур амьсгалын өөрчлөлтийг бизнесийн төлөвлөлт хийж сурах боломж гэж харуулсан</i>	26.4%	28.0%	40.3%	31.7%
<i>Уур амьсгалын өөрчлөлтийг бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харуулсан</i>	51.4%	42.7%	43.8%	43.9%
<i>Уур амьсгалын өөрчлөлтийг бусад боломж гэж харуулсан</i>	9.3%	9.6%	3.4%	4.9%

*Эх сурвалж: Судалгааны үр дүн*

## 3.2 Уулзалт, ярилцлагын авсан чанарын судалгааны үр дүн

### 3.1.1 Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөж болон тулгамдаж буй асуудал

Тус бүлэг нь ХАА-н салбарын жижиг дунд бизнес эрхлэлтийг дэмжих үндэсний түвшний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилготой бөгөөд, оролцогч талуудтай хийсэн ярилцлага, асуулга судалгааны үр дүнгүүд болон анхдагч мэдээлэлд тулгуурлан бүс нутгийн хэмжээнд нэгтгэн дүгнэж гүйцэтгэсэн.

Үндэсний түвшинд хэрэгжүүлэхээр батлагдсан бодлого хөтөлбөрүүд, тэр дундаа хүнсний үйлдвэрлэлийн хувьд ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөр, мал аж ахуйн хувьд Монгол мал үндэсний хөтөлбөр, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, газар тариалангийн хувьд Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр, Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр зэрэг бодлого хөтөлбөрүүд орон нутагт нийтлэг байгаагаас гадна тухайн орон нутгийн шинж чанартай дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Хууль эрх зүйн хүрээнд, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай, Тариалангийн тухай, Хүнсний тухай, Органик хүнсний тухай, Таримал ургамлын үр сортын тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хууль гэх мэт хууль эрх зүйн зүйл заалтууд хэрэгжиж байна.

#### А. Хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

**Баруун бүс (Ховд, Завхан):** Хэрэгжилтийн явц: ЖДҮДС, Хоршоо дэмжих хөтөлбөр гэх мэт олон хөтөлбөр хэрэгжиж байна. ААН-үүдийн хувьд зээлийн эргэн төлөлт нь маш сайн байгаа хэдий ч, жижиг болон дунд шатны ААН-ийн хамрагдах байдал, хүртээмж муу байна. Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох тал дээр анхаарч ЖДҮ-ийг дэмжих тал дээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд иргэдэд газар тариалангийн зориулалтаар газар олгох, технологийн сургалт явуулах, түүхий эд материалын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал: Ховд аймагт чанарын судалгаанд оролцсон төрийн байгууллагын, ТББ, аж ахуй эрхлэгчдийн төлөөллүүд хамгийн их тулгамдаж буй асуудал нь ААН-үүдийг дэмжих бодлого хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт маш өндөр гэж хариулсан бөгөөд барьцаа хөрөнгийн шаардлага ихтэй, үл хөдлөх хөрөнгө барьцаалдаг хөдлөх хөрөнгө барьцаанд авдаггүй тул санхүүжилтийн өөр эх сурвалж, үүсвэрээр зээл авч байгаа нь өрийн дарамтад орох эрсдэл их тулгарч байна. Мөн хамгийн сүүлийн жилийн жишээгээр буюу 2022 оны хувьд Ховд аймагт 500 сая төгрөгийг ЖДҮДСангаас хуваарилсан боловч дөнгөж л 160 сая төгрөгийг жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон байгаа нь хөтөлбөрүүдийн тавигдаж буй шаардлага өндөр байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.



Завхан аймгаас чанарын судалгаанд хамрагдсан оролцогчид мөн адил төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн зээлийн шалгуур өндөр байгаагаас шалтгаалан санхүүжилтийн 50-60 хувь нь буцаж байгаа бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг бууруулах шаардлагатай, мөн нөгөө талаас зээлийн шалгуур хангасан ААН-үүдийн хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хадгалах тал дээр хүндрэлтэй асуудлууд үүсэж байна гэж хариулсан байна.

Ач холбогдол: Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох тал дээр анхаарч ЖДҮ-ийг дэмжих тал дээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд иргэдэд газар тариалангийн зориулалтаар газар олгох, технологийн сургалт явуулах, түүхий эд материалын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

**Хангайн бүс (Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл):** Хэрэгжилтийн явц: Төмс, үр тариа, эрчимжсэн аж ахуйн бодлого, Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр”, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр, “Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлого хөтөлбөрүүдийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр салбарын уулзалт, зөвлөгөөн, сургалт, уулзалтаар хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн мэдээлэл хүргэж, чадавхижуулж ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал: Баянхонгор, Өвөрхангай аймгуудын тулгамдаж байгаа асуудлуудын хувьд, бичил болон жижиг үйлдвэрүүд, хувиараа аж ахуй эрхлэгчид зээлийн шалгуурыг хангаж чаддаггүй, зээлийн эрх зөвхөн эргэлтийн хөрөнгөнд олгож байгаа учир дутагдалтай. Орон нутагтийн хэмжээнд бүтээгдэхүүн борлуулах зах зээл хомс, төв суурин газар болон Улаанбаатар хот зэрэг зах зээл ихтэй газруудруу тээвэрлэлт хийж бүтээгдэхүүнээ борлуулах боломж хомс, зориулалтын буюу стандартын агуулах хэрэгцээ шаардлагатай байна.

Тухайн бүсийн аймгуудын жижиг дунд бизнес эрхлэгчдэд үндэсний болон орон нутгийн хэмжээнд төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрт хамрагдахын тулд зээлийн шаардлага буюу барьцаа хөрөнгө, бичиг баримт бүрдүүлэлт нийцдэггүй гэх мэт асуудлууд гарч байна. Хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрүүдийн мэдээлэлийн хувьд тухайн бүсийн бүх аймгийн сумдуудад хүртээмж муутай, мөн шаардлага хангах буюу санхүү болон эргэлтийн хөрөнгийн судалгаа, суурь мэдлэг дутмаг байна.

Ач холбогдол: Аж ахуй эрхлэгчдийн хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа үүсгэх зэрэг асуудлууд дээр тусгай зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь ач холбогдол ихтэй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан тус тус олгож байна.

**Төвийн бүс (Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ):** Хэрэгжилтийн явц: Асуулгад оролцсон оролцогчид арилжааны банкуудаар дамжуулан олгож байгаа 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл, ЖДҮДС, ОНХС болон сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь жижиг, дунд болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж байгаа нь санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгож, үр өгөөж сайтай байна.

Тулгамдаж буй асуудал: Сэлэнгэ, Дархан, Орхон аймгуудын төрийн төлөөллөөс авсан чанарын судалгаанд нийтлэг тал байгаагаас дурдвал бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахад төрийн захиргааны байгууллагын хүн хүч дутмаг, нэг мэргэжилтэнд олон асуудал хариуцуулах, ижил төстэй судалгааг олон удаа авч жижиг, дунд үйлдвэрийн хэрэгжилт хариуцаж буй мэргэжилтэн болон бизнес эрхлэгч нарт чирэгдэл учруулах зэрэг зохион байгуулалтын асуудлууд, мөн харьяа яам, орон нутгийн түвшинд хөдөө аж ахуйн чиглэлээр жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөрөнгө оруулалт тусгагдсан төсөв хөрөнгийг бүрэн шийдвэрлэхгүй байх буюу зарим тохиолдолд төсөвлөсөн хөрөнгийн тодорхой хувь буцаагдах зэрэг төсвийн зохицуулалтын асуудлууд тулгарч байна гэж хариулсан бол. Нөгөө талаас хувийн аж ахуй, жижиг дунд бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бага, төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэмжээнд хамрагдах хандлага, оролцоо бага байна гэж хариулсан байна.

**Зүүн бүс (Дорнод, Хэнтий):** Хэрэгжилтийн явц: Дорнод аймагт хоршоог хөгжүүлэх сан, ЖДҮ-ийн бодлогын хэрэгжилтийн хувьд хангалттай хэмжээний зээл олгосноос гадна хоршооны орлогын татваргүй нөхцөл бүрдүүлсэн байна.

Тулгамдаж буй асуудал: Хэнтий аймгийн асуулгад оролцогчдын хувьд сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай, хүний нөөцийг бэлтгэх сургалт, бодлого дутмаг, хоршооноос бусад бизнес эрхлэгчдэд татварын дарамт үүсэж байгаа нь төрийн бодлогын хэрэгжилт муу гэж дүгнэсэн бөгөөд ЖДҮ-н зээл хүртээмж багатай байгаагаас үйл ажиллагааны төлөвлөлт өөрчлөгдөх, зээлийн дарамтад орох эрсдэлд орж байна. Мөн зээлийн хуваарилалтын хувьд шалгуур үзүүлэлтээс гадуурх хүчин зүйлс нөлөөлж байна. Төрийн албан хаагчдын хувьд ур чадвар дутагдалтай, аж ахуй эрхлэгчдэд мэдээлэл дутмаг хүрэх зэрэг асуудлууд тулгарч байна.

#### Б. Хүнсний үйлдвэрлэлийн салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, Монгол улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон аймгуудын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж байна. Тухайн салбарт тусгайлсан төсөл хөтөлбөр одоогоор байхгүй байгаа бөгөөд, Засгийн газраас олгож буй хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд тэргүүлэх чиглэлд хүнсний үйлдвэрлэл тусгагдсан байна.

**Баруун бүс (Ховд, Завхан):** Хэрэгжилтийн явц: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шууд дэмжсэн бодлого одоогоор байхгүй байна. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэмжих талаар бодлогуудаас илүүтэйгээр санхүүжилтрүү чиглэн үйл ажиллагаа их байна. Улмаар санхүүжилт авч чадсан ААН-үүдэд сайн үр дүн өгч байна.

Тулгамдаж буй асуудал: Хүнсний үйлдвэрлэлд гол хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлууд нь зориулалтын агуулах, тээвэрлэлтийн дутмаг байдал байгаа бөгөөд төрийн бодлого, хөтөлбөр заавал шаардлагагүйгээр ААН хоорондын хамтын ажиллагаагаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа бол төрийн зүгээс нэн

шаардлагатай хэрэгжүүлэх асуудал нь тоног төхөөрөмж, техник импортоор оруулж ирхэд татварын бодлогоор дэмжих нь чухал байна.

**Хангайн бүс (Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл):** Хэрэгжилтийн явц: Бүс нутгийн дэд бүтэц хөгжсөн, дотоодын аялал жуулчлал их байдагтай холбоотойгоор хүнсний үйлдвэрлэлийн хувьд зах зээл сайн. Мөн тухайн орон нутгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд хоршоо нөхөрлөлүүд нилээдгүй хувь эзэлж байна.

Тулгамдаж буй асуудал: Тулгамдаж байгаа асуудлын хувьд, үйлдвэрлэгчид зах зээл дахь эрэлтийг хангаж чадахгүй байгаа учир, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх, хангалттай хүний нөөцтэй байх зэрэг асуудлууд нэн түрүүнд тулгарч байна.

Ач холбогдол: Хувийн хэвшил, төрийн бус байгууллага, холбоо, нөхөрлөл, хоршоодын хоорондын хамтын ажиллагаа улам сайжирч байгаа нь орон нутгийн хэмжээнд малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, мах ногооны зоорь, дунд болон бичил үйлдвэрүүдийг хамтарч байгуулах, үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрийн хүчин чадал нэмэгдүүлэх нэмэлт санхүүжилт олох зэрэг боломжууд үүсэж байна.

**Төвийн бүс (Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ):** Хэрэгжилтийн явц: Хөдөө аж ахуйн жижиг дунд бизнес эрхлэгчдэд тусгайлан зориулсан бодлого хөтөлбөр хэрэгжээгүй байгаа хэдий ч орон нутгийн харья байгууллагуудын хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөнд хүнсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээнүүдийг тусган ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал: Газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбарын хүрээнд тухайн орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах үүрэгтэй орон нутгийн засаг захиргааны ажлын албаны ажил удааширалтай байгаа нь ажлыг эхлүүлэхэд тулгамдсан асуудлын нэг болоод байна. Салбарын ажлын нэгдсэн нэг бодлогоор удирдах, салбар хоорондын уялдаа холбоо хангахад анхаарах хэрэгтэй. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулах.

Малчид, тариаланчид бүтээгдэхүүний нийлүүлэлтээ баталгаажуулах, баримтжуулах мэдлэг, хандлага дутагдалтай. Өрхийн үйлдвэрлэгч нарын хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарын талаарх мэдлэг дутмаг байна.

Ач холбогдол: Хүнсний үйлдвэрлэлийн зах зээлийн боломж бүрэн нээлттэй байна. Үйлдвэрлэгчид урт хугацааны бодлого барьж ажиллах, борлуулах. Төрийн байгууллагууд орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих замаар худалдан авалт хийх, хоршоо, холбоодын засаглал сайжрах бүрэн боломжтой байна.

**Зүүн бүс (Дорнод, Хэнтий):** Хэрэгжилтийн явц: Хүнсний үйлдвэрлэлийн салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Тулгамдаж буй асуудал: Дорнод аймагт ЖДҮ-г дэмжих төв байгуулагдсан ба гарааны бизнесүүдийг төрөл харгалзахгүйгээр дэмжиж эхний жилүүдэд нь түрээсгүй байраар хангаж ажиллаж байна. Мөн нөгөө талаас холбогдох хуулиудад хөнгөлөлт чөлөөлөлтийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа хэдий ч Хэнтий аймгийн хувьд мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна.

В. Тээвэр, агуулахын салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

**Баруун бүс (Ховд, Завхан):** Хэрэгжилтийн явц: Ховд аймгийн хувьд улсын төсвийн хөнөнгөөр иж бүрэн хагас автомажсан ногооны зоорь барьсан байна. Завхан аймгийн хувьд хувь хүмүүсийн уламтжлалт зоорь байдаг бөгөөд зөвхөн өөрсдийн хэрэгцээнд ашигладаг байна.

Тулгамдаж буй асуудал: Ховд аймгийн хувьд зоорийн үйл ажиллагааг хоршоонд шилжүүлж ААН-ийн тооцоотой, хариуцлагын эрхийг өгч үр өгөөжийг дээшлүүлэх зорилготой ажиллаж байна. Харин тээврийн хувьд төрийн шууд бодлого, зохицуулалт хийгдэх боломжгүй тохиолдолд түлш, шатхууны хөнгөлттэй хөтөлбөр хэрэгжүүлэх замаар нэгж ачаа тээвэрлэлтийн зардал буурч ААН-дэд бодит дэмжлэг болхоор байна.

**Хангайн бүс (Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл):** Хэрэгжилтийн явц: Тээвэр агуулахын салбарт чиглэсэн бодлого хөтөлбөр байхгүй байна.

Тулгамдаж буй асуудал: Тухайн бүсийн аймгуудын чанарын болон тоон судалгаанд оролцогдын хариултаас үзэхэд ихэнх аж ахуй хувиараа тээврийн асуудлаа шийддэг бөгөөд нийт ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй тээврийн компаниуд, хувь хүмүүсийн хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тусгайлан, ангилсан хэлбэрээр тээвэр эрхэлсэн байгууллага болон хувь хүн одоогоор байхгүй байна. Дэд бүтэц болон бусад салбар хөгжлийн асуудалд тусгах шаардлагатай.

**Төвийн бүс (Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ):** Хэрэгжилтийн явц: Орон нутгийн засаг захиргаанаас сумд багуудад агуулах барих замаар түүхий эд нийлүүлэх, чанартай түүхий эд гарган авах тал дээр сурталчилгаа хийж байна.

Тээврийн хувьд тогтсон бодлого баримт бичиг байхгүй байгаа бөгөөд, аж ахуй эрхлэгчид бүгд хувиараа шийдэж байна.

Автотээвэр, төмөр зам, шуудан холбооны тээврийн үйлчилгээ үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр дагнасан тээвэр үйлчилгээ байхгүй байна.

Тулгамдаж буй асуудал: Хүнс, тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага орон нутагт бүртгэлгүй, хүнсний аюулгүй байдлын хяналт сул. Бүртгэл, хөдөлгөөнийг улсын хэмжээнд бүртгэдэг болох, хяналтад авах шаардлагатай гэж хариулсан байна. Мөн бодлогын уялдаа, хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй байдалтай байна.

Ач холбогдол: Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хүнс, тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхлэгчдийн талаар суурь судалгаатай болсон нь ач холбодол өндөртэй байсан бөгөөд аж ахуйн нэгж болгонд зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байлгахгаас гадна, аймаг, сумд хоорондын хүнс, түгээлтийн үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай.

**Зүүн бүс (Дорнод, Хэнтий):** Хэрэгжилтийн явц: Зоорийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр эхлүүлж байна.

Тулгамдаж буй асуудал: Орон нутгийн хэмжээнд ногооны агуулах барьсан хэдий ч стандартын шаардлага хангаагүй учир зориулалтаар нь ашиглах боломжгүй байна.

3.2.2 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор арилжааны банкнаас олгож буй зээлийн бүтээгдэхүүн

А. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнесийг дэмжихээр банкнаас өөрийн санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүний хувьд: Судалгаа авсан нийт байршлуудын хувьд жижиг, дунд бизнесийг дэмжих талаар Хэнтий аймгаас бусад орон нутагт зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэн ажиллаж байна.

Зээлийн бүтээгдэхүүний төрлийн хувьд эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл, малчны зээл, ногоон зээл зэрэг зээлийг нийтлэг олгож байгаа бөгөөд эдгээр зээл нь сарын 1.5-1.9 хувийн хүүтэй, зээлийн дундаж хугацааны хувьд хоёроос гурван жилийн хугацаатай, эргэн төлөлтийн хувьд нийт судалгаанд оролцсон аймгуудын хувьд хэвийн байна. Нийтлэг олгож байгаа зээлийн бүтээгдэхүүнүүдийн дундаж олголт буюу нэгж аж ахуйд ногдож буй зээлийн хэмжээ хувьд харьцангуй бага хэмжээтэй мөн зээл авч буй аж ахуйн тоо бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад их байгаа нь жижиг болон бичил бизнес эрхлэгчдийн хамрагдалт их байгаатай холбоотой байна.

Б. Өөрийн санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүнд тавьдаг гол шалгуур үзүүлэлтүүдийн хувьд: Өөрийн санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн шалгуур үзүүлэлтүүд нь орон нутгийн банкуудын хувьд нийтлэг шинжтэй байгаа бөгөөд зээл хүсэгчдийн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, дансны хуулга буюу орлого зарлагын харьцаа, тэдгээрийн бүртгэл зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан зээлийн судалгаа хийж байна.

В. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнесийг дэмжихээр банкнаас бусад санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүний хувьд: Судалгаа авсан нийт байршлуудын хувьд жижиг, дунд бизнесийг дэмжих талаар Завхан аймгаас бусад орон нутагт зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэн ажиллаж байна.

Зээлийн бүтээгдэхүүний төрлийн хувьд Жайка төслийн зээл, Зээлийн батлан даалтын сангийн зээл, Монголбанкны Репо санхүүжилтийн зээл зэрэг зээлүүдийг нийтлэг олгож байгаа бөгөөд эдгээр зээл нь сарын өөрийн санхүүжилтээр олгож буй зээлээс харьцангуй бага хүүтэй, зээлийн дундаж хугацааны хувьд урт хугацаатай байна. Мөн нийт судалгаанд оролцсон аймгуудын банкны төлөөлөл нийт зээлийн бүтээгдэхүүнүүдийн шаардлага, онцлог, зээл олголтын судалгаа зэргээс хамааран эргэн төлөлт хэвийн байна гэж хариулсан байна.

Бусад санхүүжилтийн хувьд төрөөс хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, олон улсын төсөл хөтөлбөр зэрэг санхүүжилтийн эх үүсвэрээс арилжааны банкуудаар дамжин олгогдож байна.

Г. Бусад санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүнд тавьдаг гол шалгуур үзүүлэлтүүдийн хувьд: Бусад санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн шалгуур үзүүлэлтүүд нь орон нутгийн банкуудын хувьд нийтлэг шинжтэй байгаа бөгөөд өөрийн санхүүжилтийн эх үүсвэрээр олгож буй зээлийн шалгуураас ялгаатай тал нь төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилттай зээлд тухайн төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон банкны үндсэн шалгуур үзүүлэлтүүд буюу зээлийн түүх, барьцаа хөрөнгө зэрэг эрсдлийг харгалзан зээлийн судалгаа хийж байна.

Д. Өөрийн болон бусад эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүнд хамрагдахад хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлын хувьд: Өөрийн болон бусад эх үүсвэрээр олгож буй зээлийн бүтээгдэхүүнд хамрагдахад хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг судлахын тулд орон нутгийн банкны төлөөлөлтэй уулзаж ярилцлагын аргаар асуулга асууж дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Санхүүгийн мэдлэг, чадвар дутмаг: бизнесийн орлого, зарлагын харьцааг зохицуулах банкны дансаар хүлээж авах гаргах, дансны мэдээлэл зөв хөтлөх, барьцаа хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, эрсдлийн тооцоолол, татварын мэдлэг зэрэг асуудлуудтай тулгарч байна.
- Зах зээлийн судалгаа: жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийн зах зээлийн судалгаа дутмаг, тооцоолол хийдэггүй, тухайн орон нутгийн болон боломжит зах зээлийн хэмжээ, борлуулалтын боломж, нэмэлт суваг зэрэг зах зээлийн тооцоо судалгааны асуудлуудтай тулгарч байна.

### 3.3 Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудлууд

Энэхүү бүлэгт бид ХАА-н гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ цэний сүлжээний ерөнхий зураглалыг өмнө хийгдсэн өөрсдийн болон олон улс, дотоодын бусад судлаачид, байгууллагуудын судалгааны ажлуудын тайлан буюу хоёрдогч эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мөн энэхүү суурь судалгааны ажлын хүрээнд бидний авсан хээрийн судалгаанд хамрагдсан оролцогч талуудтай хийсэн ярилцлага судалгаа, асуулга судалгааны үр дүнгүүд тулгуурлан тэдгээрийг нэгтгэн дүгнэж гүйцэтгэлээ. 3.3 дугаар дэд бүлэг нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд;

- Газар тариалангийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал болон тулгамдаж буй асуудал
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал болон тулгамдаж буй асуудал

#### 3.3.1 Газар тариалангийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал


Газар тариалангийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд энэхүү судалгааны ажлын судалгаанд хамрагдсан бүртгэлтэй болон бүртгэлгүй аж ахуй эрхлэгчдийн бэлтгэн үйлдвэрлэж буй нийтлэг бүтээгдэхүүнүүдийг сонгон авсан. Үүнд:

1. Төмс, хүнсний ногоо;
2. Үр тариа, тэжээл.

#### А. Төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээ, тулгамдаж буй асуудал

**Төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал:** Монгол Улсын төмс, хүнсний ногооны зах зээлийн өнөөгийн байдлыг Үндэсний статистикийн хороо, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны мэдээллүүд, өөрсдийн өмнө хийсэн болон дотоодын, олон улсын бусад судлаачдын судалгааны тайлан, зөвлөмжүүд болох хоёрдогч тоон мэдээллүүд, мөн бидний энэхүү суурь судалгааны хээрийн судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн санал зэрэгт тулгуурлан төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээний зураглалыг дараах байдлаар тодорхойлж харуулав.

Зураг 19. Төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НҮТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018

Төмс, хүнсний ногооны бүтээгдэхүүнүүдэд хаана, хаана өртөг шингээж байгааг нийтлэг байдал (төмс, хүнсний ногооны хувьд ерөнхийд нь) -аар дараах байдлаар тайлбарлав.

Дээрх зургаас харахад суваг 1-ийн хувьд олон шат дамжлагатайгаар эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байгаа ба үүнтэй холбоотойгоор тухайн бүтээгдэхүүнд өртөг шингээх нь бусад сувгийг бодвол өргөн хүрээтэй байна. Ялангуяа дундын зууч буюу ченжүүд нь тариаланчдаас зах зээлийн үнээс 20-25% доогуур үнээр худалдан авч худалдан авсан үнэ дээр 20-30%-ийн ашиг нэмж бөөний төв болон жижиглэн худалдаачдад борлуулах замаар ашиг олж байна. Суваг 2-ын хувьд үйлдвэрлэгчээс худалдааны байгууллага хүртэлх үйлдвэрлэгчээс гарсан зардал, өртгүүд, мөн худалдааны байгууллагаас өөрсдийн гаргасан зардал, өртгийг шингэх байдлаар эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг нийлүүлэгдэж байна. Харин суваг 3-ийн хувьд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн өртөг, тээвэрлэлтийн зардал болон бусад холбогдох зардал (хадгалалт гэх мэт), мөн ашиг/алдагдлын хувь хэмжээ нэмэгдэх замаар тухайн бүтээгдэхүүн эцсийн хэрэглэгчдэд очиж байна.

**Тулгамдаж буй асуудал:** Монгол улсын төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:


- Төмс, хүнсний ногооны тариалангийн машин, техник, тракторын хүрэлцээ муу бөгөөд шатах тослох материалын зардал өндөр байна. Хүрэлцээ муу байдлаас хамааран тариалалт, хураалтын үеийн төлөвлөсөн ажлуудад өөрчлөлт оруулж байна.
- Тариалалтад технологийн нормыг бүрэн баримтлахгүй байгаа нь бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Ээлжлэн тариалалтын системийг бүрэн хэрэгжүүлдэггүй. Мөн хөрсний үржил шимийг нөхөн сэргээх үйл ажиллагаа байхгүй байгаа нь эргээд ургацын хэмжээнд сөрөг нөлөө үзүүлж байна.

- Хөдөөгийн санхүүгийн үйлчилгээ сул, зээлийн хүү өндөр байна.
- Импортын төмс, хүнсний ногооны дотоод зах зээлд үзүүлэх нөлөөлөл хүчтэй, газар тариалангийн салбарт ажиллагсдын цалин хөлс бага байна.
- Төмс, хүнсний ногоо боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил маш муу, завсарын худалдаачид, ченжүүдийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл их байна.
- Зах зээлд оролцогч талуудын хоорондын зохицуулалт болон стандартын шаардлага хангасан зоорины хүрэлцээ муу байна.
- Эрдэс бордоо, ариутгалын бодисыг үндсэндээ 100 хувь импортолж байгаа ба гадаад зах зээлийн хүчин зүйлсээс хамааран үнэ өсөх, тариаланчид нормын дагуу хэрэглэх боломжийг хязгаарлаж байгаа зэрэг үндсэн тулгамдсан асуудлууд байна.

### Б. Үр тариа, тэжээлийн үнэ цэний сүлжээ, тулгамдаж буй асуудал

**Үр тариа, тэжээлийн үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал:** Манай орны хувьд 390 орчим мянган га талбайд үр тариа тариалж буй бөгөөд үүний 90 орчим хувьд улаанбуудай тариалж байна. Үр тариа (улаанбуудай)-ны зах зээлд оролцогч талуудад МУЗГ буюу Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Хөдөө аж ахуйг дэмжих сан (ХААДС), Гурил үйлдвэрлэгчид, Тариалан эрхлэгчид, мэргэжлийн холбоодоос бүрэлдэж байна. 2022 оны байдлаар 800 орчим тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүд 357.9 гаруй мянган га талбайд улаанбуудай тариалж байна. Дээрх тариаланчид сүүлийн 10-н жилийн дунджаар жилдээ 370 орчим мянган тонн улаанбуудай хурааж авсан бөгөөд үүнийг 100 хувь дотоодын хэрэгцээнд зарцуулсан байна. Хураан авсан улаанбуудайныхаа 62 хувийг гурил үйлдвэрлэлд (үүнд: 9 хувь нь ХААДС-д, үлдсэн хувийг гурилын үйлдвэрүүдэд), 11 хувийг үрийн буудайнд, 9 хувийг тэжээлийн үйлдвэрт, 4 хувийг спиртийн үйлдвэрүүдэд тус тус нийлүүлжээ (Буяннэмэх, 2021). Бид үр тариан үнэ цэний сүлжээний зураглалыг тодорхойлохдоо улаанбуудайг төлөөлүүлэн үзэж өөрсдийн болон бусад олон улс, дотоодын судлаачид, байгууллагуудын судалгааны тайлан мэдээнд дүн шинжилгээ хийн өнөөгийн нөхцөл байдлыг схемчилж харууллаа.

Зураг 20. Үр тариа (улаанбуудай)-ны үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НУТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018



Тариаланчид үр тариан арилжааг хийхдээ гурил үйлдвэрлэгч, ХААДС, болон Спирт, тэжээлийн үйлдвэртэй харилцан тохиролцож борлуулалтаа хийж байна. Хэдийн хуулийн зохицуулалт байдаггүй ч ХААДС-д авах улаан буудайн үнийг засгийн газраас тогтоож байгаа нь тухайн жилийн улаан буудайн жишиг үнэ болсоор ирсэн байна. Жил бүр борлуулалтыг ямар нэг хуулийн зохицуулалтгүй, эрэлт нийлүүлэлтийн үндсэн дээр хийж байна.

**Тулгамдаж буй асуудал:** Үр тариа, тэжээлийн үнэ цэний сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Газар зүй, цаг уурын онцлог, ялангуяа ургамал ургах улирал богино, хур тунадас бага унадаг, тархац нь зохистой бус харьцаатай, салхинаас үүдэлтэй хөрсний доройтол зэрэг нь газар тариалан эрхлэгчдэд ихээхэн хүндрэлийг бий болгож байна. Хөрс бордолт, сэлгэн тариалалт хангалттай хийдэггүй, ургамал хамгааллын арга хэмжээ маш бага авч байна.
- Үр тариа тариалж буй иргэд, аж ахуй нэгжүүд зах зээлээс зайтай, тээврийн зардал өндөр, агуулах савны хүрэлцээгүй зэрэг тулгамдаж буй асуудлууд тулгардаг.
- Одоогийн үр тарианы нийлүүлэлтийн сүлжээнд тулгамдаж буй чухал асуудал нь үр тариа тээвэрлэх машины хүрэлцээ бөгөөд чанарын шаардлага хангасан тогтвортой тээврийн хэрэгслүүд маш ховор байна.
- Манай улсын үр тарианы зах зээлд үр тарианы чанар, ангиллын үнэлгээ лаборатори тус бүрд харилцан адилгүй байгаа нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд томоохон асуудал болж байна.
- Үр тариан аж ахуйн нь улирлаас хэт хамааралтай тул жил бүр тогтмол ургац авч чадахгүй байгаагаас гурил, тэжээлийн хангамж, чанарт шууд нөлөө үзүүлж байна.
- Төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдийн хувьд улаанбуудайнд чиглэсэн олон баримт бичгүүд байдаг ба бусад төрлийн үр тариа, тэжээлийн таримлуудын зах зээлийг дэмжсэн бодлого хөтөлбөр ховор байна.
- Үр тариаг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал, нормын хувьд учир дутагдалтай байдаг нь тус зах зээлд оролцогч талуудын хооронд үл ойлголцол бий болгож байна.

### 3.3.2 Мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд энэхүү судалгааны ажлын судалгаанд хамрагдсан бүртгэлтэй болон бүртгэлгүй аж ахуй эрхлэгчдийн бэлтгэн үйлдвэрлэж буй нийтлэг бүтээгдэхүүнүүдийг сонгон авсан. Үүнд:

1. Мах, махан бүтээгдэхүүн;
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн.


#### А. Мах, махан бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээ, тулгамдаж буй асуудал

**Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал:** Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн байдал, дотоодын болон олон улсын судлаачид, байгууллагуудын судалгаа, судалгааны ажлын тайлан зөвлөмж зэрэг хоёрдогч эх сурвалжууд болон бидний энэхүү суурь судалгааны хээрийн судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн санал зэрэгт тулгуурлан мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээний системийг дараах байдлаар тодорхойлж харуулав. Махны үнэ цэний

сүлжээ нь (1) маллагаа, нядалгаа, (2) тээвэрлэх, борлуулах, туувар, (3) боловсруулах, ангилах, савлах, (4) тээвэрлэх, хадгалах, (5) борлуулах гэсэн ерөнхий таван хэсгээс бүрддэг байна. Малыг маллаж, нядалж, тээвэрлэж, тууж, борлуулах хүртэлх үе шатыг Үйлдвэрлэлийн, тээвэрлэж, тууж, худалдан авахаас боловсруулж, ангилах, савлахыг дамжиж, тээвэрлэх, хадгалах хүртэлх шатыг Завсрын, тээвэрлэх, хадгалахаас борлуулах хүртэлх шатыг Маркетингийн шат гэж тус тус нэрлэнэ (INRAE, 2018).

Монгол Улсын махны үнэ цэний сүлжээ нь малчин, дундын зуучлагчид буюу олон нийтийн хэлж заншсанаар “ченжүүд”, боловсруулах үйлдвэр, хиамны үйлдвэр, цех, бөөний худалдааны төв, зах ба жижиглэнгийн худалдаа, супермаркет, дэлгүүр, Улаанбаатар хотын ба хот, суурин газрын хувь хэрэглэгч, ресторан, зоогийн газар, гуанз ба экспортын хэрэглэгч гэсэн үндсэн таван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна.

Зураг 21. Мах, махан бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НУТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018

Малчдын гар дээрээс гарч буй мах нь малын зах, хүнсний зах, бөөний худалдааны төв болон жижиглэнгийн худалдаагаар дамжиж Улаанбаатар хот болон хүн ам төвлөрсөн суурин газрын хэрэглэгчид, ресторан, зоогийн газруудад нийлүүлэгдэж байгаа бол дундын зуучид болон боловсруулах үйлдвэрүүдийн бие төлөөлөгчдөөр дамжиж боловсруулах үйлдвэрүүдэд борлуулагдаж байна. Дундын зуучлагчид (ченж) малчдаас хүлээн авсан мал, махныхаа тодорхой хэсгийг боловсруулах үйлдвэр, хиамны үйлдвэр, цехүүдэд тушааж, үлдсэн хэсгийг Улаанбаатар хотын болон томоохон хот, суурин газруудын мал, махны захад нийлүүлдэг. Малчдаас болон дундын зуучлагчдаас гарч буй мах боловсруулалт хийгдээгүй буюу түүхий хэлбэрээр борлуулагддаг. Харин боловсруулах үйлдвэрүүдээр дамжиж буй мах бүрэн болон хагас боловсруулалт хийгдэж, бөөний болон жижиглэнгийн худалдаагаар дамжиж дотоодын, экспортын худалдаагаар дамжин гадаад зах зээлд эцсийн хэрэглэгчдэд хүрч байна.

Нийт үйлдвэрлэгдсэн махны үнэ цэний сүлжээнд хэрхэн хуваарилагдаж эцсийн хэрэглэгчдэд хүрч байгааг тодорхойлохыг оролдсон боловч дундын зуучдаар, бөөний ба жижиглэнгийн худалдаагаар дамжин борлогдож байгаа ба ресторан, зоогийн газрын хэрэглэсэн махны хэмжээтэй холбоотой мэдээлэл хомс байна. Иймд цаашид махны үнэ цэний сүлжээгээр дамжсан махны хуваарилалтыг зөв тооцохын тулд дээрх мэдээллүүдийг тодорхой болгох нь чухал юм (INRAE, 2018).

**Тулгамдаж буй асуудал:** Махны нийлүүлэлтийн сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг авч үзэхийн тулд тус нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрээр асуудлуудыг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

- Нийлүүлэлтийн сүлжээний эхний шат болох маллагаа, нядалгааны үе шатанд эн тэргүүнд бэлчээр доройтол, усны нөөц хомсдсон, малын өвчлөл, тэжээлийн болон хөдөлмөрийн нөөц дутмаг байдал хамгийн ихээр тулгамдсан асуудал болж байна.
- Харин тээвэрлэх, борлуулах, түүвэр хийх шатанд тээвэрлэх, зах зээлд нийлүүлэх оновчтой сүлжээ бүрдээгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн нэгдсэн тогтолцоо муу, мөрддөггүй, дундын зуучлагчид нөлөө их, мах хадгалах зориулалтын агуулах маш их дутагдалтай байдаг байна.
- Боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологи хоцрогдсон, мах бэлтгэх эргэлтийн хөрөнгө дутмаг, боловсруулалтын түвшин доогуур зэрэг нь нийтлэг бэрхшээлүүд байна.
- Боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах шатанд ложистикийн хувьд дутмаг, дэд бүтэц сул хөгжсөн, чөлөөт бүс, гаалийн үйл ажиллагаа удаан зэрэг бэрхшээлүүдийг махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд шийдвэрлэх шаардлагатай аж.
- Борлуулах шатанд Монгол Улс малын өвчлөлийн идэвхтэй бүсэд багтдаг тул гадны хэрэглэгчдийн итгэх итгэл сул, үүнээс гадна импортлогч орнуудын тарифын бус хязгаарлалтууд, өндөр татвар зэрэг нь махны экспортод сөрөг нөлөө үзүүлж байна.

Эдгээрээс гадна махны экспортыг нэмэгдүүлэхэд олон улсын экспортын чанарын шаардлагад нийцэхгүй байна.

#### Б. Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээ, тулгамдаж буй асуудал

**Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал:** Манай орны сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн байдал, бидний өмнө хийсэн болон дотоод, гадаадын судлаачид, байгууллагуудын хийсэн судалгаа, судалгааны ажлын тайлан, зөвлөмж зэрэг хоёрдогч эх сурвалжууд, мөн энэхүү суурь судалгааны хүрээнд хийсэн хээрийн судалгааны асуулга, фокус ярилцлагын үр дүнгээс гарсан үйлдвэрлэгчдийн санал, зөвлөмжүүдэд тулгуурлан мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээний системийг дараах байдлаар тодорхойлж харуулав.

Зураг 22. Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НҮТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018

Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээнд оролцогчдыг дараах байдлаар ангилж байна. Үүнд: Бэлтгэн нийлүүлэгч, Үйлдвэрлэгч, Борлуулагч, Хэрэглэгч.

Бэлтгэн нийлүүлэгч нь улсын хэмжээний 188.6 мянган малчин өрх /2021 оны тоо/, үүний дотор 3035 сүүний чиглэлийн үхрийн ферм /2021 оны тоо/ юм. Бэлтгэн нийлүүлэгчид нь түүхий сүүг өрхийн хэрэгцээнд болон зах зээл дээр нийлүүлж байна. Улсын хэмжээнд бэлтгэж байгаа 859.0 сая литр сүүний 88.0 сая литрийг сүүний чиглэлийн үхрийн фермүүд, 771.2 сая литр сүүг малчин өрхүүд бэлтгэсэн ба үүний 31.7 сая литр түүхий сүүг үйлдвэрт нийлүүлсэн байна.

Фермүүдийн бэлтгэсэн сүүг ихэвчлэн сүү боловсруулах үйлдвэрүүд гэрээний үндсэн дээр худалдан авдаг бол малчин өрхийн бэлтгэсэн сүүний багахан хувь нь сүү боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэгддэг байна. Сүүний үйлдвэрүүд сүүг худалдан авахдаа дулааны улиралд өөрсдийн хөргөх цех дээр хүлээн авдаг бол хүйтний улиралд шууд цистернээр цуглуулж авдаг. Зарим тохиолдолд зуучлагчидаас худалдан авалт хийдэг байна.

Малчин өрхөөс зах зээлд нийлүүлэгдэж байгаа сүү нь түүхий сүүгээр нийлүүлэгдэхээс гадна уламжлалт аргаар боловсруулсан сүүн бүтээгдэхүүн хэлбэрээр шууд болон зуучлагчдаар дамжин нийлүүлэгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хүнсний тухай хуулийн 8.3, 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг Засгийн

газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлуулан 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Журамд шаардлага хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд 1 литр тутамд таван зуун төгрөгөөр тооцож олгохоор заажээ. Мөн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бэлтгэн нийлүүлсэн түүхий шингэн сүүнд урамшуулал олгох эрх зүйн орчин бүрдэж, сүү боловсруулах үйлдвэрүүд хэрэглэгчдийг үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сүүгээр хангах, улирлын хамаарлыг бууруулах, дотоодын хэрэгцээг тогтвортой хүртээмжтэй, хангах нөхцөл бүрдэж эхэлсэн .

**Тулгамдаж буй асуудал:**

- Бэлчээрийн доройтол, усны хомсдол зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж малын тэжээл хомсдосоноос болж мал давжаарч, уургийн дутагдал, дархлааны сулралд орсон.
- Эрчимжсэн сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэхэд хүний нөөц дутагдалтай, хөрөнгө оруулалт их шаардагддаг байна.
- Мал эмнэлгийн үйлчилгээ, чанар хүртээмж муу, малын тэжээлийн олдоц бага байгаагаас сүүний гарц болон чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Алслагдсан бүс нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чанарын шаардлага хангасан үйлдвэр, цех байхгүйгээс тус бүсүүдэд бэлтгэгдэж буй сүү, сүүн бүтээгдэхүүнүүд уламжлалт аргаар боловсруулагдсан эсвэл түүхийгээр дотоодын зах зээлд хямд үнээр нийлүүлэгдэж байна. Энэ нь экспортлох боломжгүй болж, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Сүүг цуглуулахад чанар, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл хомсдолтой байна.
- Сүүний боловсруулах үйлдвэрүүдэд мэргэжлийн хүний нөөц хомсдолтой, салбарын мэргэжилтэн бэлтгэл муу байна.
- Борлуулах шатанд Монгол Улс малын өвчлөлийн идэвхтэй бүсэд багтдаг тул гадны хэрэглэгчдийн итгэх итгэл сул, үүнээс гадна импортлогч орнуудын тарифын бус хязгаарлалтууд, өндөр татвар зэрэг нь сүү, сүүн бүтээгдэхүүний экспортод сөрөг нөлөө үзүүлж байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

### 4.1 Дүгнэлт

Судалгааны үр дүнд үндэслэн үндэсний болон зорилтот салбарын түвшинд гол гол дүгнэлтүүдийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

#### Макро эдийн засгийн түвшинд:

- Манай улсын эдийн засагт хөдөө аж ахуй боловсруулах үйлдвэрлэлийн салбар эерэг нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, сүүлийн таван жилийн дунджаас харахал хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 0.9 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 1.3 пунктээр тус тус өссөн байна.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт оруулж буй нэмэр сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. 2015 онд ДНБ-ий 4.7-ийг бүрдүүлж байсан бол 2021 онд 5.5 хувь болж өссөн байна.

#### Мал аж ахуйн салбарын хувьд (төсөл хэрэгжиж буй бүс нутгийн түвшинд):

- Салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 8.6 дахин өндөр орлоготой байна.
- Давхардсан тоогоор бүртгэлтэй нийт 177 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 2059 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 53 хувь нь байнгын ажлын байр байна. Харин бүртгэлгүй нийт 29 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 231 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 34 хувь нь байнгын ажлын байр байна.
- Байнгын ажлын байрны хувьд бүртгэлтэй бизнес эрхлэгчид бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 2 дахин их байнгын ажлын байр бий болгож байна. Өөрөөр хэлбэл, давхардсан тоогоор нийт 177 бүртгэлтэй бизнес эрхлэгчид 1093 ажлын байранд ажиллагсад ажиллуулж, нэг бүртгэлтэй бизнес эрхлэгч дунджаар 6 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байна. Харин бүртгэлгүй 29 бизнес эрхлэгчийн хувьд нийт 79 байнгын ажлын байранд ажиллагсад ажиллуулж, нэг бүртгэлтэй бизнес эрхлэгч дунджаар 3 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байна.
- Байнгын ажлын байранд эмэгтэйүүдийн эзлэх хувь 47.8%-50.6% хооронд байхад, түр ажлын байранд 34.4%-52.0% хооронд байна.
- Бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж хэдий ч ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 50 гаруй хувь нь төлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна.
- Мөн сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байр нийтлэг тогтвортой хадгалагдсан байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 86 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 83 орчим хувь нь ажлын байрны тоонд өссөн, буурсан өөрчлөлт гараагүй гэсэн үр дүн гарсан.
- Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 78.7 хувь байна.
- Бизнес эрхлэгчдийн ихэнх нь буюу 80 гаруй хувь нь үйлдвэрлэлийн төлөвлөлтийг 60-с дээш хувьтай хэрэгжүүлж байна.

- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 57.1 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 37.8 хувь нь 1-2 жилийн хугацаатай бизнес төлөвлөлт боловсруулж байна.
- Бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь буюу 60 гаруй хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг хэдий ч, нөөцийг төрлөөр ангилан бүртгэх нь учир дутагдалтай буюу 20 гаруй хувь нь нөөцийг төрлөөр нь ангилан бүртгэж байна.
- Судалгаанд хамрагдсан нийт 760 нэгжээс ISO нэвтрүүлсэн 27 бизнес эрхлэгч, бүгд бүртгэлтэй бизнес эрхлэгчид ба мал аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдээс энэхүү нэвтрүүлэлт хийгдээгүй байна.
- Бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа болон олон нийтийн сүлжээ байна. Мөн бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.
- Нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувьд нь санхүүгийн, 50 гаруй хувьд нь техник, тоног төхөөрөмжийн, 20 гаруй хувьд нь хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 97 орчим хувьд, бүртгэлгүй бизнес эрхлэгчдэд 100 хувь санхүүгийн хэрэгцээ үүсээд байгаа ба бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 80 орчим хувь нь ойрын хугацаанд зээл төлөвлөж байгаа, мөн бүртгэлтэй бизнес эрхлэгчид дунджаар 150 орчим сая төгрөгийн, бүртгэлгүй бизнес эрхлэгчид 100 орчим сая төгрөгийн зээлийн хэрэгцээ үүсээд байна гэж тодорхойлсон.
- Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй, нөгөө талаас ажиллах хүч олдоггүй гэсэн үр дүн харагдаж байна.
- Хүний нөөцтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь цалин, урамшуулал нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах болон мэргэжил, ур чадварын сургалт явуулах гэсэн үр дүн харагдаж байна.
- Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна.
- Ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна. Үүнийг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах нь гол арга зам гэдэг нь энэхүү судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Салбарын бизнест уур амьсгалын өөрчлөлт 100 хувь эрсдэл учруулж байгаа ба 95.2 хувь нь их болон маш их эрсдэл учруулж байна гэж үзэж байна. Мөн эрсдэл учруулж байгаа гол хүчин зүйлст цаг агаарын эрс тэс байдал, ган, зуд болон байгалийн нөөцийн хомсдол багтаж байна.
- Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийг өөрийн бизнест боломж гэж харж байгаа бизнес эрхлэгчид 70 орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд ихэнх хувь нь шинэ техник, технологи нэвтрүүлэх, бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харж байна.

#### Газар тариалангийн салбарын хувьд (төсөл хэрэгжиж буй бүс нутгийн түвшинд):

- Салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 9.3 дахин өндөр орлоготой байна.
- Давхардсан тоогоор бүртгэлтэй нийт 225 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 5905 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 28 хувь нь байнгын ажлын байр байна. Харин бүртгэлгүй нийт 67 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 919 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 20 орчим хувь нь байнгын ажлын байр байна.
- Байнгын ажлын байрны хувьд бүртгэлтэй бизнес эрхлэгчид бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 1.5 дахин их байнгын ажлын байр бий болгож байна. Өөрөөр хэлбэл, дунджаар бүртгэлтэй нэг бизнес эрхлэгч 9 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байхад бүртгэлгүй бизнес эрхлэгчийн хувьд 6 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байна.
- Байнгын ажлын байранд эмэгтэйүүдийн эзлэх хувь 47.9%-50.3% хооронд байхад, түр ажлын байранд 47.6%-67.2% хооронд байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж хэдий ч ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 50 гаруй хувь нь төлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна. Харин бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 50 гаруй хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж, ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 20 гаруй хувь нь төлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт байна.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байр нийтлэг тогтвортой хадгалагдсан байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 82 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 93 орчим хувь нь ажлын байрны тоонд өссөн, буурсан өөрчлөлт гараагүй гэсэн үр дүн гарсан.
- Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 77.5 хувь байна.
- Бизнес эрхлэгчдийн ихэнх нь буюу 78 орчим хувь нь үйлдвэрлэлийн төлөвлөлтийг 60-с дээш хувьтай хэрэгжүүлж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 57.8 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 35.8 хувь нь 2 жилийн хугацаатай бизнес төлөвлөлт боловсруулж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 72 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 42 орчим хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг хэдий ч, 22 хүрэхгүй хувь нь нөөцийг төрлөөр ангилан бүртгэж байна.
- ISO 9001:2015, ISO14001:2015 болон ISO45001 стандартыг газар тариалангийн салбарын маш цөөхөн бизнес эрхлэгчид нэвтрүүлээд байна.
- Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа, үзэсгэлэн худалдаа болон олон нийтийн сүлжээ байна. Мөн бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.



- Нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувьд нь санхүүгийн, 60 гаруй хувьд нь техник, тоног төхөөрөмжийн, 30 гаруй хувьд нь хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 98.2 хувьд, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 98.5 хувьд нь санхүүгийн хэрэгцээ үүсээд байгаа ба бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 80 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь ойрын хугацаанд зээл төлөвлөж байна. Мөн бүртгэлтэй бизнес эрхлэгчид дунджаар 340 гаруй сая төгрөгийн, бүртгэлгүй бизнес эрхлэгчид 80 орчим сая төгрөгийн зээлийн хэрэгцээ үүсээд байна гэж тодорхойлсон.
- Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч нэг талаас тогтвор суурьшилтай ажилладаггүй, нөгөө талаас ажиллах хүч олдоггүй, мөн цалингийн түвшин хангалтгүй гээд ажилладаггүй гэсэн үр дүн харагдаж байна. Үүнийг шийдвэрлэх гол замыг цалин, урамшуулал нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах болон мэргэжил, ур чадварын сургалт явуулах гэж харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байсан.
- Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна. Мөн ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна. Үүнийг арилгахад санхүүгийн туслалцаа авах, ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах, мөн ажил олгогч талаас мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Салбарын бизнест уур амьсгалын өөрчлөлт 100 хувь эрсдэл учруулж байгаа ба 96.3 хувь нь их болон маш их эрсдэл учруулж байна гэж үзэж байна. Мөн эрсдэл учруулж байгаа гол хүчин зүйлст цаг агаарын эрс тэс байдал болон ган, зудын үзэгдэл багтаж байна.
- Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийг өөрийн бизнест боломж гэж харж байгаа бизнес эрхлэгчид 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа бөгөөд ихэнх хувь нь шинэ техник, технологи нэвтрүүлэх, бизнесийн төлөвлөлт хийж сурах болон бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харж байна.

Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд (төсөл хэрэгжиж буй бүс нутгийн түвшинд):

- Салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 6.3 дахин өндөр орлоготой байна.
- Давхардсан тоогоор бүртгэлтэй нийт 229 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 4057 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 74 орчим хувь нь байнгын ажлын байр байна. Бусад зорилтот салбаруудтай харьцуулахад энэхүү үзүүлэлт өндөр байна. Харин бүртгэлгүй нийт 57 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 303 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 60 орчим хувь нь байнгын ажлын байр байна. Бусад салбаруудтай харьцуулахад мөн адил өндөр үзүүлэлт гарсан байна.
- Байнгын ажлын байрны хувьд: Бүртгэлтэй бизнес эрхлэгчид бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 4.1 дахин их байнгын ажлын байр бий болгож байна. Өөрөөр хэлбэл,

дунджаар бүртгэлтэй нэг бизнес эрхлэгч 13 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байхад бүртгэлгүй бизнес эрхлэгчийн хувьд 3 хүн байнгын ажлын байранд ажиллуулж байна.

- Байнгын ажлын байранд эмэгтэйүүдийн эзлэх хувь бусад харьцуулахад өндөр буюу 60.8%-76.1% хооронд байна. Түр ажлын байранд 52.1%-56.1% хооронд байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж, ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувь нь төлж байна. Харин бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд 100 хувь нь байнгын болон түр ажлын байранд аль алинд нь эсвэл байнгын/түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж байгаа хэдий ч ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 20 орчим хувь нь төлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт байна.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байр харьцангуй тогтвортой хадгалагдсан байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 72.5 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 77.2 хувь нь ажлын байрны тоонд өссөн, буурсан өөрчлөлт ороогүй гэж хариулсан байна.
- Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 73.0 хувь байна.
- Бизнес эрхлэгчдийн ихэнх нь буюу 84 орчим хувь нь үйлдвэрлэлийн төлөвлөлтийг 60-с дээш хувьтай хэрэгжүүлж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 63.8 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 26.3 хувь нь 1-2 жилийн хугацаатай бизнес төлөвлөлт боловсруулж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 78.6 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 42.1 хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг ба нийт бизнес эрхлэгчдийн 40 гаруй хувь нь нөөцийг төрлөөр ангилан бүртгэж байгаа нь бусад зорилтот салбараас ялгаатай байна.
- ISO 9001:2015, ISO14001:2015 болон ISO45001 стандартыг маш бага бизнес эрхлэгчид нэвтрүүлээд байна.
- Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа, үзэсгэлэн худалдаа болон олон нийтийн сүлжээ байна. Мөн бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна.
- Нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувьд нь санхүүгийн, 70 орчим хувьд нь техник, тоног төхөөрөмжийн, 40 гаруй хувьд нь хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 98.7 хувьд, бүртгэлгүй бизнес эрхлэгчдэд 100 хувь санхүүгийн хэрэгцээ үүсээд байгаа ба бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 80 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь ойрын хугацаанд зээл төлөвлөж байна. Мөн бүртгэлтэй бизнес эрхлэгчид дунджаар 400

орчим сая төгрөгийн, бүртгэлгүй бизнес эрхлэгчид 60 орчим сая төгрөгийн зээлийн хэрэгцээ үүсээд байна гэж тодорхойлсон.

- Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй гэсэн үр дүн харагдаж байна. Үүнийг шийдвэрлэх гол замыг цалин, урамшуулал нэмэгдүүлэх гэж харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байсан.
- Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна. Мөн ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна. Үүнийг арилгахад санхүүгийн туслалцаа авах, ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах, мөн ажил олгогч талаас мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Салбарын бизнест уур амьсгалын өөрчлөлт 100 хувь эрсдэл учруулж байгаа ба 90.2 хувь нь их болон маш их эрсдэл учруулж байна гэж үзэж байна. Мөн эрсдэл учруулж байгаа гол хүчин зүйлст түүхий эд, материалын хомсдол, цаг агаарын эрс тэс байдал болон ган, зудын үзэгдэл багтаж байна.
- Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийг өөрийн бизнест боломж гэж харж байгаа бизнес эрхлэгчид 66 орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд ихэнх хувь нь шинэ техник, технологи нэвтрүүлэх болон бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харж байна.

#### Тээвэр, агуулахын салбарын хувьд (төсөл хэрэгжиж буй бүс нутгийн түвшинд):

- Салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн хувьд бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 8.5 дахин өндөр орлоготой байна.
- Давхардсан тоогоор бүртгэлтэй нийт 70 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 1460 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 73 орчим хувь нь байнгын ажлын байр байна. Харин бүртгэлгүй нийт 17 бизнес эрхлэгчдийн хувьд нийт 125 ажлын байранд ажиллах хүч ажиллуулж байгаа ба үүний 33 орчим хувь нь байнгын ажлын байр байна. Бусад салбаруудтай харьцуулахад мөн адил өндөр үзүүлэлт гарсан байна.
- Байнгын ажлын байрны хувьд: Бүртгэлтэй бизнес эрхлэгчид бүртгэлгүй бизнес эрхлэгчдээс 6.3 дахин их байнгын ажлын байр бий болгож байна.
- Байнгын ажлын байранд эмэгтэйүүдийн эзлэх хувь бусад харьцуулахад өндөр буюу 39.0%-41.1% хооронд байна. Түр ажлын байранд 30.9%-32.1% хооронд байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 81.4 хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж, ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 66 орчим хувь нь төлж байна. Харин бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн хувьд 50 гаруй хувь нь байнгын болон түр ажлын байранд хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллагсад ажиллуулж байгаа хэдий ч ажил олгогчоос төлөх ёстой НДШ-ийг нийт бизнес эрхлэгчдийн 24 орчим хувь нь төлж байна.

- Сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын байр харьцангуй тогтвортой хадгалагдсан байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 77.1 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 94.1 хувь нь ажлын байрны тоонд өссөн, буурсан өөрчлөлт ороогүй гэж хариулсан байна.
- Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 73.9 хувь байна.
- Бизнес эрхлэгчдийн ихэнх нь буюу 74 орчим хувь нь үйлдвэрлэлийн төлөвлөлтийг 60-с дээш хувьтай хэрэгжүүлж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 45.7 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 23.5 хувь нь 1-2 жилийн хугацаатай бизнес төлөвлөлт боловсруулж байна.
- Бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 60 орчим хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 30 орчим хувь нь нөөцийн бүртгэл хөтөлдөг ба нийт бизнес эрхлэгчдийн 30 хүрэхгүй хувь нь нөөцийг төрлөөр ангилан бүртгэж байна.
- Судалгаанд хамрагдсан нийт 760 нэгжээс ISO нэвтрүүлсэн 27 бизнес эрхлэгч, бүгд бүртгэлтэй бизнес эрхлэгчид ба салбарын бизнес эрхлэгчдээс энэхүү нэвтрүүлэлт хийгдээгүй байна.
- Салбарын бизнес эрхлэгчид бусдад өөрийн бизнесийг танилцуулахад ашигладаг гол суваг нь танил тал, найз нөхдийн харилцаа болон олон нийтийн сүлжээ байна. Мөн бүртгэлтэй болон бүртгэлгүй бизнес эрхлэгчид зорилтот худалдан авагч, нийлүүлэгчидтэй холбоо тогтоодог гол суваг нь өөрийн биеэр уулзаж холбоо тогтоодог явдал байна. Бусад салбаруудтай харьцуулахад энэхүү хэлбэрээр холбоо тогтоох байдал нь илүү өндөр хувьтай байна.
- Нийт бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувьд нь санхүүгийн, 60 гаруй хувьд нь техник, тоног төхөөрөмжийн, 30 гаруй хувьд нь хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
- Бүртгэлтэй нийт бизнес эрхлэгчдийн 93 орчим хувьд, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 94 гаруй хувьд нь санхүүгийн хэрэгцээ үүсээд байгаа ба бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 74.3 хувь нь, бүртгэлгүй бизнес эрхлэгчдийн 70.6 хувь нь ойрын хугацаанд зээл төлөвлөж байна. Мөн бүртгэлтэй бизнес эрхлэгчид дунджаар 100 орчим сая төгрөгийн, бүртгэлгүй бизнес эрхлэгчид 180 гаруй сая төгрөгийн зээлийн хэрэгцээ үүсээд байна гэж тодорхойлсон.
- Хүний нөөцтэй холбоотой гол тулгамдаж буй асуудал нь ажиллах хүч тогтвор суурьшилтай ажилладаггүй гэсэн үр дүн харагдаж байна. Үүнийг шийдвэрлэх гол замыг цалин, урамшуулал нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах гэж харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байсан.
- Шинээр хүн авч ажиллуулахад байгууллагаас зөөлөн ур чадварыг илүү чухалчилж авч үздэг нь харагдаж байна. Мөн ажил олгогч талаас шаарддаг зөөлөн ур чадвар болон ажил горилогчоос цалингийн түвшин хангалтгүй гэж үзэж байгаа шалтгаанууд гол зөрүүтэй байдлыг бий болгож байна. Үүнийг арилгахад санхүүгийн туслалцаа авах болон ажил горилогчдыг чадавхжуулах сургалт явуулах нь зүйтэй харж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

- Салбарын бизнест уур амьсгалын өөрчлөлт 100 хувь эрсдэл учруулж байгаа ба 90.8 хувь нь их болон маш их эрсдэл учруулж байна гэж үзэж байна. Мөн эрсдэл учруулж байгаа гол хүчин зүйлд цаг агаарын эрс тэс байдал багтаж байна.
- Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийг өөрийн бизнест боломж гэж харж байгаа бизнес эрхлэгчид 47.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд ихэнх хувь нь шинэ техник, технологи нэвтрүүлэх болон бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харж байна.

Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж асуудлууд ажлын үр дүнд үндэслэн дүгнэх нь (үндэсний түвшинд):

ХАА-н гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ цэний сүлжээний ерөнхий зураглалыг өмнө хийгдсэн өөрсдийн болон олон улс, дотоодын бусад судлаачид, байгууллагуудын судалгааны ажлуудын тайлан буюу хоёрдогч эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мөн энэхүү суурь судалгааны ажлын хүрээнд бидний хээрийн судалгаанд хамрагдсан оролцогч талуудтай хийсэн ярилцлага судалгаа, асуулга судалгааны үр дүнгүүдэд тулгуурлан тэдгээрийг нэгтгэн дүгнэж гүйцэтгэсэн.

Үүний тулд газар тариалангийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийг төлөөлүүлж судалгаанд хамрагдсан аж ахуй эрхлэгчдийн нийтлэг бүтээгдэхүүн болох төмс, хүнсний ногоо болон үр тариа, тэжээл, мал аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийг төлөөлүүлж мөн нийтлэг байдлаар мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглалыг зурж, үнэ цэний сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон. Нийтлэг байдлаараа дээрх 4 төрлийн бүтээгдэхүүнүүдийн талаар нийлүүлэлтийн сүлжээний үе шатууд дахь судалгаа, бодит мэдээллүүд ховор байгаа тул нэмэгдсэн өртгийг тооцож, үнэ цэнүүдийг нарийвчлан тодорхойлох боломжгүй байна.

- Төмс, хүнсний ногооны үнэ цэний сүлжээний хувьд өнөөгийн байдлаар дундын зууч буюу ченжийн нөлөө тус зах зээлд хүчтэй нөлөө үзүүлж байна. Энэхүү төмс, хүнсний ногооны тариалангийн техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, цаг агаар, байгалийн хүчин зүйлээс ихээхэн хамааралтай, технологи, үр, сортын шинэчлэл сул байна. Мөн бордоо, ургамал хамгааллын бодисын хангамж импортоос шууд хамааралтай байгаа төдийгүй хүний нөөц дутагдалтай, санхүүгийн үйлчилгээ сул хөгжсөн байгаа зэрэг нь үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулж байна.
- Үр тариа, тэжээлийн үнэ цэний сүлжээний хувьд нийт тариалантын ихэнх буюу 90 орчим хувь нь улаанбуудай тариалж байгаа ба үрийн тогтвортой, чанартай байдал, тариалангийн технологийн хоцрогдол, чанар стандартын зөрүүтэй байдал, хөрсний ядуурал, техник тоног төхөөрөмжийн дутагдал, хүний нөөцийн дутагдал, байгаль цаг уураас ихээхэн хамааралтай байдал, тээвэрлэлтийн хүрэлцээгүй байдал, санхүүгийн хомсдол зэрэг нь тариаланчдад хүндрэл бэрхшээлүүдийг дагуулж байна. Зах зээлийн хувьд МУЗГ-с ХААДС-нд авах буудайн үнийг тогтоосноор зах зээлийн жишиг үнийг бий болгодог байна. Улаанбуудайнаас бусад төрлийн үр тарианы аж ахуйг дэмжих бодлого сул

байгаа нь тариаланчид ээлжлэн тариалалт гэх мэт үр ашигтай технологиудыг нэвтрүүлэхэд удаашралтай болгож байна.

- Мах, махан бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээнд мөн дундын зууч буюу ченжүүдийн нөлөө маш өндөр байгаа ба малчдаас зах зээлийн үнээс хямдаар худалдан авч бөөний болон жижиглэнгийн худалдаачдад ашиг нэмэг зарж, зах зээлийн үнийг өсгөх боломжтой болдог байна. Энэхүү түүхий эд, бүтээгдэхүүний хувьд бэлчээрийн доройтол, ус, тэжээлийн хомсдол, хүний нөөцийн дутагдал, малын халдварт өвчин зэрэг нь малын ашиг шимийг бууруулж, чанарыг муутгах үндэс болж байна. Зах зээлийн хувьд нэмүү өртөг шингэсэн хагас боловсруулсан болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл нийт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй ихэнх хэрэглэгчид үйлдвэрийн бус аргаар бэлтгэсэн түүхий махыг хэрэглэж байгаа нь эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдалд хүндрэл учруулж байна. Үйлдвэрүүдийн хувьд технологийн хоцрогдол, санхүүжилтийн хомсдол, эрүүл ахуй, ариун цэврийн тогтолцоо сул зэрэг асуудлууд байгаагаас экспортын шаардлагуудад нийцэхгүй байх хүндрэлүүд элбэг байна.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний ерөнхий зураглалаас үзэхэд түүхий эдийг цуглуулах систем төвийн бүсүүдэд харьцангуй ахицтай байгаа бөгөөд төрөөс дэмжих бодлогын үр дүнд сүүний үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна. Гэвч малын халдварт өвчин, бэлчээрийн доройтол, ус, тэжээлийн хомсдол, хүний нөөцийн дутагдал, зэрэг нь түүхий эд бэлтгэлд сөрөг үр нөлөөтэй хэвээр байна. Ялангуяа эрчимжсэн сүүний үхрийн аж ахуй эрхлэхэд хөрөнгө оруулалт их шаарддаг ба үйл ажиллагааны зардал өндөр байдаг байна. Манай орны хувьд мал эмнэлгийн үйлчилгээ, чанар, хүртээмж муу байгаа нь эцсийн бүтээгдэхүүний чанарын баталгааг алдагдуулж буй бөгөөд экспортод нийлүүлэх боломжийг хязгаарлаж байна. Мөн алслагдсан бүсэд боловсруулах үйлдвэр, цех хомс байгаа нь тухай нутгийн бэлтгэсэн сүүг уламжлалт үйлдвэрийн бус аргаар боловсруулж, зах зээлд нийлүүлэхээс өөр аргагүйд хүргэж байна.

#### **4.2 Санал**

##### **Нэг. Суурь судалгааны үр дүн болон дүгнэлтэд үндэслэн БҮХ ЗОРИЛТОТ САЛБАР-г нийтлэгч хамаарах дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:**

- Эрхэлж буй бизнесийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх бус харин тухайн бизнесийн үйл ажиллагааг илүү сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Хууль эрх зүйн мэдлэг, тэр дундаа хөдөлмөрийн харилцаа, зохицуулалтын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх.
- Бараа материалын нөөцийн бүртгэл, бизнес төлөвлөлтийг илүү сайн хөглөх, боловсруулахад нь мэргэжлийн туслалцаа / зөвлөгөө үзүүлэх.
- Олон улсын чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлтэд чиглэсэн санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа / зөвлөгөө үзүүлэх.
- Бизнесийн харилцааг албан ёсны болгоход мэргэжлийн туслалцаа / зөвлөгөө үзүүлэх.

- Санхүүгийн дэмжлэг туслалцаа, мэргэжлийн зөвлөгөө/туслалцаа үзүүлэх боломж нөхцөл, хувилбарыг боловсруулж, үүнд чиглэсэн арга хэмжээг хүртээмжтэй хүргэхэд анхаарах.
- Зээлийн санхүүжилтийн механизм, шалгуур үзүүлэлтийг жижиг бизнес эрхлэгчдэд чиглэн анхаарч авах, уян хатан болгох.

**Хоёр. Үнэ цэний сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж асуудлууд бүлгийн хүрээнд хийсэн ажлын үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:**

ХАА-н гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ цэний сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх нь бүс нутагт төдийгүй улс орны эдийн засаг, хүн амын хүнсний хангамж, эрүүл мэнд, ажлын байр зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л төвшинд таатай нөхцөлийг бий болгох боломжтой юм.

- Үнэ цэнийн сүлжээн дэх оролцогч талуудын хүртэж буй ашгийн хуваарилалтыг тодорхойлох шаардлагатай. Өөрөөр хэлбэл үнэ цэнийн сүлжээнд багтаж буй ямар оролцогч их ашиг хүртэж байгаа болон ямар оролцогчийг хэрхэн дэмжиж хүртэж буй ашгийг нь нэмэгдүүлж болох, эмзэг оролцогчийг тодорхойлох нарийвчилсан судалгаа хийх.
- Үнэ цэнийн сүлжээн дэх сайжруулах боломжтой чиглэлүүдийг тодорхойлж, бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, савлагааг сайжруулах, эсвэл үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломж, шинэ технологи үйлдвэрлэлд хөрөнгө оруулах эсвэл дахин зохион байгуулах замаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процессыг сайжруулах, үнэ цэнийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх боломжийг судлах.
- Төвийн бүс эсвэл Баруун болон Зүүн, Хангайн бүс тус бүрээр үнэ цэний сүлжээг ялган хийж нэгтгэх нь тухайн бүс бүрийн онцлог, шинж чанар, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам зэргийг нарийн тодорхойлох боломжийг олгохоор байна.
- Үнэ цэнийн сүлжээн дэх оролцогч талуудын харилцан уялдаа холбоо, хамтран ажиллах арга хэлбэрийг тодорхойлох. Өөрөөр хэлбэл үнэ цэнийн сүлжээг бүхэлд нь хэрхэн уялдуулж ажиллуулах, удирдах арга замыг тодорхойлох зүйтэй юм.
- Үр ашигтай технологи, төхөөрөмжүүдээр хангах, чадварлаг хүний нөөцийг сургаж бэлдэх талаар бодлого авч хэрэгжүүлэх, үр үрсэлгээ, малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах шаардлагатай.
- ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн арилжаагаар дэлхийд тэргүүлэгч улс орнуудын туршлагыг судлан манай орны орчинд нийцүүлсэн бизнесийн загвар гаргах. Тухайлбал таваарын биржийг хөгжүүлэх, бодлого, хууль эрхзүйн орчныг сайжруулж, ил тод, нээлттэй, шударга өрсөлдөөнийг бий болгох хэрэгцээтэй байна. ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн боловсруулах үйлдвэрүүдийг чанар стандартыг хангасан, дэвшилтэт технологи бүхий үр ашигтай ажиллуулах талаар нэгдсэн бодлогоор хангаж чадавхжуулах, экспортын шаардлагуудыг бүрэн хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ❖ Азийн Хөгжлийн Банк (2020 он). Монгол Улсын хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийн сүлжээ, Хэвлэлийн дугаар. TCS210023-3 DOI: <http://dx.doi.org/10.22617/TCS210023-3>;
- ❖ А.Бат-Эрдэнэ (2015 он) Мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээр ашиглалт. Paper presented at the "Хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүс" нээлттэй хэлэлцүүлэг, Улаанбаатар, Монгол улс;
- ❖ Б.Бадарч, С.Бадарч, Т.Эрдэнэчулуун (2014 он). Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ цэний сүлжээ, санхүүжилт, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Н.Батжаргал (2016 он) Төмсний зах зээлийн "РАМ" шинжилгээ. Докторын диссертаци. Хөдөө аж ахуйн их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Г. Ганзориг, Г. Энх-Амгалан, Т. Эрдэнэчулуун, О. Амартүвшин нар (2018 он). Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт:2 SECiM C2 төсөл, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Г.Мөнхбаясгалан, Я.Отгонсүрэн нар (2013). Хэрэглэгчийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа, Монголын хүн амын сэтгүүл, Дугаар (390) 22, 2013, Улаанбаатар, Монгол Улс;
- ❖ Мирим Консалтант (2018), Малчдад зориулсан гарын авлага, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Монголын Махны Холбоо (2017). Монгол Улсын махны нэмүү өртгийн сүлжээний нөхцөл байдлын судалгаа, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Н.Отгонсайхан (2018 он). Монгол Улс, ОХУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдал, “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018-09, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Ө.Ганбаатар, Г.Энх-Амгалан (2016). Хэнтий аймгийн газар тарилангийн салбар: Төмс, хүнсний ногооны зах зээлийн судалгаа, “Каритас Чех Републик” олон улсын байгууллага, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ П.Буяннэмэх (2021 он). “ХААБ-ээр хүнсний улаан буудай дамжуулан худалдаалах дериватив зах зээлийн судалгаа”, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ ХААБ (2022 он). “Махны нийлүүлэлтийн тогтолцоо” судалгааны тайлан, Улаанбаатар хот, Монгол Улс;
- ❖ Artangeral, Khulan. 2014. “Mongolia’s Meat Supply Chain Management: Benchmarking with Australian Meat Supply Chain.” School of Management and Economics, a PowerPoint presentation;
- ❖ Brane Novaković (2014). Analysis of value chain for meat and meat products;
- ❖ Bellù, L. G. (2013) Value Chain Analysis for Policy Making - Methodological Guidelines and country cases for a Quantitative Approach;
- ❖ Coulier and Wilderspin (2016), “Enhancing adaptive capacity of women and ethnic minority smallholder farmers through improved agro-climate information in South-East Asia” (ACIS) - project baseline study;
- ❖ Giuli Keshelashvili (2018), Value chain management in agribusiness;
- ❖ International Institute of Tropical Agriculture (IITA) (2018), Feed the Future Mozambique Improved Seeds for Better Agriculture (SEMEAR);



- ❖ Japan International Cooperation Agency (JICA) (2017), Data collection survey for agriculture and livestock sector in Mongolia;
- ❖ Japan International Cooperation Agency (JICA) (2017), Data Collection Survey on Agriculture Sector in Moldova;
- ❖ Jacques H. Trienekens (2011), Agricultural Value Chains in Developing Countries A Framework for Analysis;
- ❖ Kotim Subandi, Hermawan, Adriana Sari Aryani (2019), Value Chain Analysis Indonesian Animal Husbandry Industry;
- ❖ Prabal Barua and Syed Hafizur Rahman (2020), Sustainable value chain approach for livestock-based livelihood strategies for communities of the southeastern coast of Bangladesh;
- ❖ United Nations FAO (2021), Engaging with small and medium agrifood enterprises to guide policy-making;
- ❖ United Nations Conference on Trade and Development (2021). Survey on the Domestic and Export Meat Value Chain in Mongolia;
- ❖ United States Agency for International Development (USAID) (2007) AFE Value chain program design and promoting market-based solution;
- ❖ VACID Africa to International Rescue Committee for the Pro-Resilience Action (2016), Baseline Report for the PRO-ACT Programme;
- ❖ World Bank (2017). Mongolia's red meat value chain: Towards increasing exports to China and other key markets. Unpublished;
- ❖ World Bank (2019), Mongolia Central Economic Corridor Assessment A Value Chain Analysis of the Cashmere-Wool, Meat, and Leather Industries, Report No: AUS0000216;
- ❖ World Bank (2014), Agribusiness indicators: synthesis report.

## ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буй зорилтот салбарын үйл ажиллагааны чиглэл

Нэг. Мал аж ахуй, малын тэжээл тариалалт	Хоёр. Газар тариалангийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн машин, механизм	Гурав. Хүнсний боловсруулах үйлдвэрлэл	Дөрөв. Агуулах, тээвэр болон дундын зуучлалын үйл ажиллагаа
1.1 Малын тэжээл тариалалт	2.1 ХАА-н машин механизм, тоног төхөөрөмж	3.1 Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.1 Махны зоорины агуулахын үйл ажиллагаа
1.2 Малын үржил, селекцийн үйл ажиллагаа	2.2 Ургамал, хөрс хамгаалал	3.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.2 Хүнсний ногооны зоорины агуулахын үйл ажиллагаа
1.3 Мал эмнэлгийн үйлчилгээ	2.3 Бордоо, химийн бодис, усалгаа	3.3 Бүх төрлийн ногоо, даршилсан, нөөшилсөн ногооны үйлдвэрлэл	4.3 ХАА-н бүтээгдэхүүний савлагаа, сав баглаа боодлын үйлдвэрлэл
1.4 Сүүний аж ахуйн үйл ажиллагаа	2.4 Үр сорт	3.4 Жимс, жимсгэнийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.4 ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний дундын борлуулалт, зуучлалын үйл ажиллагаа
1.5 Махны аж ахуйн үйл ажиллагаа	2.5 Хүлэмжийн аж ахуй, тариалалт	3.5 Үр тариа, гурилын үйлдвэрлэл	4.5 ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт
1.6 Шувууны аж ахуйн үйл ажиллагаа	2.6 Төмс, хүнсний ногооны тариалалт	3.6 Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	4.6 Өвс, малын тэжээлийн агуулахын үйл ажиллагаа
1.7 Гахайн аж ахуйн үйл ажиллагаа	2.7 Жимс, жимсгэнийн тариалалт	3.7 Органик, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	
1.8 Загасны аж ахуйн үйл ажиллагаа	2.8 Үр тариа тариалалт		
1.9 Зөгийн аж ахуйн үйл ажиллагаа			
1.10 Малын тэжээл үйлдвэрлэл			

Эх сурвалж: Захиалагч талаас санал болгосон салбарын үйл ажиллагааны чиглэл

## Хавсралт 2. Суурь судалгааны орон нутагт ажиллах ажлын ерөнхий удирдамж

### “ХӨДӨӨ АЖ АХУЙН СУУРЬ СУДАЛГАА”-НЫ ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ АЖЛЫН ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

- ❖ **Төслийн товч танилцуулга:** Энэхүү суурь судалгааг Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын ОУ-ын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-ийн санхүүжилттэй, “Хөгжлийн Шийдэл” ТББ-аас хэрэгжүүлж буй “BEST ХӨТӨЛБӨР”-ийн хүрээнд хийж байна. АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй хэрэгжүүлж буй “BEST ХӨТӨЛБӨР” нь жижиг, дунд үйлдвэрлэлд олгох зээлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн засаглал, хариуцлагыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд туслах гол зорилготой 2019 оны 12 сараас эхлэн хэрэгжүүлж буй хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь:
  - ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
  - ЖДБ эрхлэгчдийн дунд компанийн засаглалыг сайжруулах;
  - Чадавхыг сайжруулах;
  - Стратегийн сургалтын талаарх аналитик хөтөлбөрийг хөтлөх болон;
  - Буцалтгүй тусламж олгох зэрэг чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

Тус хөтөлбөр нь Нийслэл Улаанбаатар хот болон Баруун бүсийн Ховд, Завхан; Хангайн бүсийн Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл; Төвийн бүсийн Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ; Зүүн бүсийн Дорнод, Хэнтий аймгуудад хэрэгжиж байна.

**Суурь судалгааны ажлын зорилго:** Хөдөө аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрлэл болон тээвэр, агуулахын салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал (бизнесийн туршлага, технологи, гол орц, орлого, зарлага, хүнсний аюулгүй байдал, хувийн хэвшлийн оролцоо, жендер гэх мэт өргөн хүрээнд)-д үнэлэлт өгч, тулгамдаж буй асуудал, сорилт, боломжийг тодорхойлох; үнийн цэний сүлжээний ерөнхий зураглал гаргах; цаашлаад төсөл хэрэгжүүлэгч нэгжид жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн зөвлөмж боловсруулж өгөхөд энэхүү суурь судалгааны зорилго оршино.

**Судалгааны хамрах цар хүрээ, объект:** Дээр дурдсан салбаруудын түвшинд 6 дэд салбар, 28 чиглэлийн үйл ажиллагаа (анги) эрхэлж буй 1000 жижиг, дунд бизнес эрхлэгчдээс энэхүү судалгааг авна. Мөн энэхүү судалгааг хөтөлбөр хэрэгжиж буй Баруун бүсийн Ховд, Завхан, Хангайн бүсийн Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон, Төвийн бүсийн Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Зүүн бүсийн Дорнод, Хэнтий аймгууд болон Нийслэл Улаанбаатар хот, түүний орчмын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчид хамрагдахаар төлөвлөн ажиллана.

Мөн чанарын өгөгдөл, мэдээлэл цуглуулах зорилгоор орон нутаг (12 аймаг)-ийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс эсвэл аймгийн ХХААГ), арилжааны банкны төлөөлөл (ХААН банк, ХАС банк, Төрийн

банк), мэргэжлийн салбарын холбоод/ТББ-ын төлөөллийг хамруулсан ганцаарчилсан уулзалт, мөн Баруун бүсээс Ховд аймаг, Төвийн бүсээс Сэлэнгэ аймаг, Зүүн бүсээс Дорнод аймгийг хамруулж, 5 хүртэл жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийг хамруулсан бүлгийн уулзалтыг зохион байгуулна. Ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг тухайн маршрут хариуцсан багийн ахлагч нар хийж гүйцэтгэнэ.

**Судалгаанд хамрагдах түүврийн хэмжээ, түүний тархаалт:** Судалгаанд хамрагдах нийт 1000 нэгжийг дээр дурдсан аймаг, нийслэл, салбараар болон бизнесийн статусаар нь бүртгэлгүй болон бүртгэлтэй бизнес эрхлэгч, дотор нь хоршоо, нөхөрлөл, орон нутгийн төрийн өмчит үйлдвэрийн газар, хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувьцаат компани гэсэн хариуцлагын хэлбэрээр тархааж, судалгаанд хамруулна. Дэлгэрэнгүй мэдээллийг хээрийн судалгааны маршрут бүрд хавсралт мэдээллээр тарааж өгнө.

**Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа, маршрут:** Суурь судалгааны өгөгдөл, мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар 05-наас 2022 оны 12 дугаар сарын 28-ныг дуустал хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бөгөөд дараах маршрутын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

**Маршрут №1.** Хангайн бүсийн Өвөрхангай, Баянхонгор аймгууд болон Баруун бүсийн Ховд, Завхан аймгууд руу хуваарилагдсан зөвлөх болон судлаач нар ажиллана.

**Маршрут №2.** Хангайн бүсийн Орхон, Хөвсгөл аймгууд болон Төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд руу хуваарилагдсан зөвлөх болон судлаач нар ажиллана.

**Маршрут №3.** Зүүн бүсийн Дорнод, Хэнтий аймгууд болон Төвийн бүсийн Дорноговь, Өмнөговь аймгууд руу хуваарилагдсан зөвлөх болон судлаач нар ажиллана.

**Маршрут №4.** Улаанбаатар хотын 9 дүүрэг болон түүний орчмын бүс рүү бүх зөвлөх болон орон нутагт ажилласан судлаач нар нэгдсэн байдлаар хамтран ажиллаж, судалгааг авна.

#### Судалгаа авахад анхаарах зүйлс:

- Судалгаа авахын өмнө оролцогчдод “BEST ХӨТӨЛБӨР” болон суурь судалгааны зорилго, ач холбогдлыг зөв ойлгуулах, тайлбарлах.
- Тухайн оролцогчоос өгсөн удирдамж, асуулгын дагуу ТАБЛЕТ дээр судалгааг авч дуусмагц төв сервер рүү мэдээллийг илгээнэ (submit).
- Тухайн өдрийн судалгааны ажлыг дуусмагц хээрийн судалгааны маршрут тус бүр дэх багийн ахлагч нар цуглуулсан өгөгдөлд дотоод мониторинг хийнэ.
- Бүртгэлгүй оролцогчдоос судалгаа авахад орон нутгийн төслийн нэгжээс дэмжлэг авч ажиллана. Орон нутгийн төслийн нэгж логистик хариуцаж ажиллана.
- Орон нутгийн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоод/ТББ, арилжааны банкны төлөөлөл болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүлгийн уулзалтын талаарх удирдамжийг чанарын судалгаа хийх ажлын удирдамжид харуулсан.
- Маршрут хариуцсан ахлагч нар судлаач нарыг орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй холбох, судалгааг авахад анхааран ажиллах.

Хавсралт 3. Тоон өгөгдөл цуглуулах судалгааны асуулга\_Хавсралт файл №1

Хавсралтаар илгээсэн “Хавсралт файл №1”-с үр дүнг харна уу.

Хавсралт 4. Чанарын өгөгдөл, мэдээлэл цуглуулах судалгааны ажлын удирдамж\_Хавсралт файл №2

Хавсралтаар илгээсэн “Хавсралт файл №2”-с үр дүнг харна уу.

Хавсралт 5. Судалгаанд хамрагдсан нэгэжийн эх олонлог\_Үйл ажиллагаа явуулж буй нийт жижиг, дунд бизнес эрхлэгч

Байришил болон харцуцлагын хэлбэр	Зорилтот салбарууд					
	Газар тариалангийн үйл ажиллагаа	Мал аж ахуй, туслах аж ахуйн үйл ажиллагаа	Мал аж ахуй болон газар тариалан хосолсон үйл ажиллагаа	Хүнсний боловсруулах үйлдвэрлэл	Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын үйл ажиллагаа	Нийт дүн
<i>Баянхонгор</i>	13	7	1	13	19	53
<i>ХК болон ХХК</i>	8	6	1	11	19	45
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	5	1	-	2	-	8
<i>Дархан-Уул</i>	37	23	8	33	17	118
<i>ХК болон ХХК</i>	34	20	8	32	17	111
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	3	3	-	1	-	7
<i>Дорноговь</i>	6	8	4	7	29	54
<i>ХК болон ХХК</i>	3	8	4	7	29	51
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	3	-	-	-	-	3
<i>Дорнод</i>	15	19	6	29	23	92
<i>ХК болон ХХК</i>	13	19	6	28	23	89
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	2	-	-	1	-	3
<i>Завхан</i>	13	4	7	11	10	45
<i>ХК болон ХХК</i>	9	1	5	8	10	33
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	4	3	2	3	-	12
<i>Орхон</i>	19	10	-	34	20	83
<i>ХК болон ХХК</i>	18	10	-	33	19	80
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	1	-	-	1	1	3
<i>Өвөрхангай</i>	11	10	3	15	12	51
<i>ОНӨҮГ</i>	-	-	-	1	-	1
<i>ХК болон ХХК</i>	5	8	2	12	12	39
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	6	2	1	2	-	11

Хавсралт 5-ын үргэлжлэл

Байриил болон хариуцлагын хэлбэр	Зорилтот салбарууд						Нийт дүн
	Газар тариалангийн үйл ажиллагаа	Мал аж ахуй, туслах аж ахуйн үйл ажиллагаа	Мал аж ахуй болон газар тариалан хосолсон үйл ажиллагаа	Хүнсний боловсруулах үйлдвэрлэл	Тээвэр, агуулах болон дундын зуучлал, борлуулалтын үйл ажиллагаа		
<i>Өмнөговь</i>	5	5	1	13	136	160	
<i>ХК болон ХХК</i>	5	3	1	13	136	158	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	-	2	-	-	-	2	
<i>Сэлэнгэ</i>	9	11	-	3	4	27	
<i>ХК болон ХХК</i>	8	8	-	3	4	23	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	1	3	-	-	-	4	
<i>Улаанбаатар</i>	449	323	172	685	1,314	2,943	
<i>ОНӨҮГ</i>	-	-	-	1	-	1	
<i>ХК болон ХХК</i>	408	218	117	670	1,309	2,722	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	8	5	3	10	4	30	
<i>Орчмын бүс</i>	33	100	52	4	1	190	
<i>Ховд</i>	19	11	2	29	34	95	
<i>ОНӨҮГ</i>	-	-	-	1	-	1	
<i>ХК болон ХХК</i>	10	7	1	23	33	74	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	9	4	1	5	1	20	
<i>Хөвсгөл</i>	15	17	5	26	7	70	
<i>ХК болон ХХК</i>	12	16	4	26	7	65	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	3	1	1	-	-	5	
<i>Хэнтий</i>	15	16	2	14	4	51	
<i>ХК болон ХХК</i>	11	13	1	12	4	41	
<i>Хоршоо, нөхөрлөл</i>	4	3	1	2	-	10	
<i>Нийт дүн</i>	626	464	211	912	1,629	3,842	

Хавсралт 6. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид (зорилтот салбар, үйл ажиллагааны тоо болон бүртгэлтэй эсэхээр)

Үйл ажиллагаа эрхэлж буй үндсэн салбар	Эрхэлж буй үйл ажиллагаа тоо						Нийт дүн
	1	2	3	4	5	6	
<b>Бүртгэлгүй</b>	<b>111</b>	<b>29</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>146</b>
<i>Зөвхөн нэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	111	13	1	1	-	-	126
<i>Мал аж ахуй</i>	7	-	-	-	-	-	7
<i>Туслах аж ахуй</i>	5	1	-	-	-	-	6
<i>Газар тариалан</i>	40	10	1	1	-	-	52
<i>Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	48	2	-	-	-	-	50
<i>Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	10	-	-	-	-	-	10
<i>Мэргэжлийн үйлчилгээ / мал эмнэлэг</i>	1	-	-	-	-	-	1
<i>Хоёр салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	-	16	2	-	-	1	19
<i>Мал аж ахуй + Газар тариалан</i>	-	1	-	-	-	-	1
<i>Мал аж ахуй + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	-	3	-	-	-	-	3
<i>Туслах аж ахуй + Газар тариалан</i>	-	4	-	-	-	1	5
<i>Газар тариалан + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	-	2	1	-	-	-	3
<i>Газар тариалан + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	6	1	-	-	-	7
<i>Гурван салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	-	-	-	-	-	1	1
<i>Газар тариалан + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	-	-	-	1	1
<b>Бүртгэлтэй</b>	<b>457</b>	<b>108</b>	<b>37</b>	<b>8</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>614</b>
<i>Зөвхөн нэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	457	71	8	1	-	-	537
<i>Мал аж ахуй</i>	29	6	-	-	-	-	35
<i>Туслах аж ахуй</i>	20	3	-	-	-	-	23
<i>Газар тариалан</i>	130	47	8	1	-	-	186
<i>Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	182	12	-	-	-	-	194
<i>Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	46	3	-	-	-	-	49
<i>Мэргэжлийн үйлчилгээ / мал эмнэлэг</i>	50	-	-	-	-	-	50
<i>Хоёр салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	-	37	28	4	-	1	70
<i>Мал аж ахуй + Газар тариалан</i>	-	12	7	-	-	-	19
<i>Мал аж ахуй + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	-	8	-	1	-	-	9
<i>Туслах аж ахуй + Газар тариалан</i>	-	2	4	-	-	-	6
<i>Туслах аж ахуй + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	1	-	-	-	1
<i>Газар тариалан + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	-	10	3	1	-	1	15
<i>Газар тариалан + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	2	9	2	-	-	13
<i>Газар тариалан + Мэргэжлийн үйлчилгээ</i>	-	1	-	-	-	-	1
<i>Хүнсний боловсруулах үйлдвэрлэл + тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	2	4	-	-	-	6
<i>Гурван салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	-	-	1	1	2	1	5
<i>Мал аж ахуй + Туслах аж ахуй + Газар тариалан</i>	-	-	1	-	1	-	2
<i>Мал аж ахуй + Газар тариалан + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл</i>	-	-	-	-	-	1	1
<i>Мал аж ахуй + Газар тариалан + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	-	-	1	-	1
<i>Туслах аж ахуй + Газар тариалан + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	-	1	-	-	1
<i>Дөрвөн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг</i>	-	-	-	2	-	-	2
<i>Мал аж ахуй + Туслах аж ахуй + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	-	1	-	-	1
<i>Мал аж ахуй + Газар тариалан + Хүнсний боловсруулах үйлдвэрлэл + Тээвэр, агуулах, дундын зуучлал, борлуулалт</i>	-	-	-	1	-	-	1

Эх сурвалж: Судалгааны үр дүн